



**МОНГОЛ УЛСЫН
ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ**

2021-2024 ОНЫ ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОВЧООН

**Улаанбаатар хот
2024 он**

МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИЙН 2021-2024 ОНЫ ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОВЧООН

Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн
Тэргүүлэгчдийн газраас эрхлэн хэвлүүлэв.

ЭМХЭТГЭСЭН:

Эрдэм шинжилгээ, мониторингийн хэлтсийн дарга, доктор (Ph.D)	С.Баяннасан
Нийгмийн шинжлэх ухааны болон Хүмүүнлэгийн ухааны салбарын бага чуулган хариуцсан эрдэмтэн нарийн бичгийн дарга, доктор (Ph.D)	А.Амарсанаа
Физик, математик, информатик болон Техник, технологийн салбарын бага чуулган хариуцсан эрдэмтэн нарийн бичгийн дарга, доктор (Ph.D)	Ц. Болортамир
Хими, биологийн болон Геологи, газарзүй, байгаль орчны салбарын бага чуулган хариуцсан эрдэмтэн нарийн бичгийн дарга, доктор (Ph.D)	Ө.Болортуяа
Төрөлжсөн Академиуд хариуцсан эрдэмтэн нарийн бичгийн дарга	Д.Энх-Амгалан
Шинжлэх ухаан амьдрал сэтгүүл, түгээн дэлгэрүүлэлт хариуцсан мэргэжилтэн, доктор (Ph.D)	Б.Золжаргал

РЕДАКТОРЛАСАН:

ШУА-ийн Ерөнхийлөгчийн үүргийг түр орлон гүйцэтгэгч, академич	Б.Авид
ШУА-ийн Дэд ерөнхийлөгч, доктор (Sc.D)	Ц.Цэрэндорж
ШУА-ийн Тэргүүлэгчдийн газрын дарга	А.Баярбаатар
Хэвлэлийн эх бэлтгэсэн:	С.Баяннасан

ШУА-ийн Тэргүүлэгчдийн газар
Хэвлэлийн хуудас:
Цаасны хэмжээ: 1/8, А4
Тоо ширхэг: 100 ширхэг
Утас: 261993, 266557

© Зохиогчийн эрхийн тухай хууль, бусад хууль эрх зүйн актын дагуу Монгол Улсын Шинжлэх
Ухааны Академийн бичгээр өгсөн зөвшөөрлөөс бусад тохиолдолд дахин хэвлэх, хувиан
олшруулахыг хориглоно.

ЭРХЭМ ХҮНДЭТ АКАДЕМИЧ ТАНАА

Монгол Улсын ШУА-ийн Ерөнхийлөгчийн ээлжит сонгууль зохион байгуулж байгаатай холбогдуулан ШУА-ийн Тэргүүлэгчдийн газар, харьяа хүрээлэнгүүдийн ажлын үр дүнгүүдийн талаарх лавлагааны товч мэдээллийг Танд хүргэж байна.

Энэхүү товчооныг ШУА-ийн Ерөнхийлөгч, академич Дүгэрийн Рэгдэлийн 2021-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн биелэлтийг Их чуулганаар хэлэлцэх үед нэмэлт мэдээлэл болгов.

Таны эрдэм номын ажилд өндөр амжилт хүсэн ерөөе.

Номын цагаан буян Таныг эгнэгт ивээн тэтгэж байх болтугай.

МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИЙН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ГАЗРЫН ХАМТ ОЛОН

ГАРЧИГ

ӨМНӨХ ҮГ	5
НЭГ. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	6
1.1 ЭРХЗҮЙН ОРЧНЫ ТАЛААР	6
1.2 УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР	9
1.3 ХҮНИЙ НӨӨЦИЙН ТАЛААР	14
1.4 ЛАБОРАТОРИЙН ОРЧИН , МАТЕРИАЛЛАГ БААЗЫГ БЭХЖҮҮЛЭХ ТАЛААР	18
1.5 ДЭД БҮТЦИЙН ТАЛААР	19
1.6 ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГАА	20
1.7 ДОТООД ХАМТЫН АЖИЛЛАГАА	24
1.8 ШИНЖЛЭХ УХААНЫ СУРТАЛЧИЛГАА, ТҮГЭЭН ДЭЛГЭРҮҮЛЭЛТИЙН ТАЛААР	28
1.9 САНХҮҮЖИЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТАЛААР	32
ХОЁР. ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, ИННОВАЦ, ТЕХНОЛОГИ	34
2.1 ШУА-ИЙН 2021-2024 ОНЫ БҮТЭЭЛИЙН ТОВЧОО	34
2.2 ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ АЖЛЫН ОНЦЛОХ ҮР ДҮНГЭЭС	37
2.3 ИННОВАЦ, ТЕХНОЛОГИЙН ТАЛААР	44
ГУРАВ. ДҮГНЭЛТ, ЗОРИЛТ	46

ӨМНӨХ ҮГ

Монгол Улсын ШУА-ийн Ерөнхийлөгчийн ээлжит сонгууль зохион байгуулж байгаатай холбогдуулан ШУА-ийн Ерөнхийлөгч, академич Дүгэрийн Рэгдэлийн 2021-2024 онд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн биелэлт, ШУА-ийн Тэргүүлэгчдийн газар, харьяа 16 хүрээлэн болон салбарын зарим хүрээлэн, төвүүдэд хийж гүйцэтгэсэн эрдэм шинжилгээ, үйл ажиллагааны талаар энэхүү тайланд товч тусгасан болно.

ШУА нь Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн эрхзүйн байдлын тухай хууль, Шинжлэх ухаан технологийн тухай хууль, Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн дүрэм болон бусад хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаа явуулж ирлээ.

Шинжлэх ухааны ажилтны анхдугаар их хурлаас УИХ, Засгийн газар, эрдэм шинжилгээ, үйлдвэрлэл, бизнесийн байгууллагууд болон мэргэжлийн холбоодод хүргүүлсэн шинжлэх ухаан, технологийн салбарт тулгамдаж буй асуудлыг цогц байдлаар хөндөн, шийдвэрлэх арга зам, гарц гаргалгааны талаарх зөвлөмж, түүнийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас гаргасан 379 дүгээр тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллалаа.

Өнгөрсөн 4 жилийн хугацаанд хэрэгжүүлсэн бодлого, үйл ажиллагааны үр дүнд шинжлэх ухаан, технологи, инновацыг олон улсын жишигт нийцүүлэн системтэйгээр хөгжүүлэх эрх зүйн үндсийг бүрдүүлсэн Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2024 оны 5 дугаар сард УИХ-аар баталлаа.

Үүнээс гадна олон улсын стандартад нийцсэн нээлттэй, салбар дундын төрөлжсөн лаборатори, технологи дамжуулах төв бүхий “Шинжлэх ухааны хүрээлэнгүүдийн нэгдсэн цогцолбор”-ын бүтээн байгуулалтын ажил төлөвлөгөөний дагуу хэрэгжиж, лабораторийн зориулалт бүхий 3 гол объектыг энэ онд багтаан ашиглалтад оруулахаар төлөвлөн ажиллаж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэвшүүлсэн санал, санаачилгууд, Засгийн газрын бодлого, үйл ажиллагааны төсөл, хөтөлбөрүүдийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд шинжлэх ухаан, технологи, инновацын ололт шийдвэрлэх үүрэгтэйг тал талдаа ухамсарлаж, хамтран ажиллах боломжийг эрэлхийлэн, мэдлэг мэдээлэл, арга туршлагаа солилцон төр, хувийн хэвшлийн байгууллагууд бүтээлчээр хамтран ажиллаж байна. Үүний нэг жишээ нь Монгол Улсын Ерөнхий сайд шинжлэх ухааны салбарын төлөөлөлтэй биечлэн уулзаж, тулгамдсан асуудлуудтай танилцсаны мөрөөр Шинжлэх ухаан, технологи, инновацын тогтолцоог хөгжүүлэх дунд хугацааны бодлогыг тодорхойлох чиг үүрэг бүхий Үндэсний шинжлэх ухаан, технологийн бодлогын хороо байгуулсан, эрдэм шинжилгээний ажилтны цалинг дунджаар 46 хувиар нэмэгдүүлсэн, эрдэм шинжилгээний хүрээлэнгүүд үйл ажиллагааныхаа үндсэн чиглэлээр төрийн болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд оролцох боломжийг нээсэн зэрэг хэд хэдэн тодорхой шийдвэр гарсан нь манай салбарынхны итгэл найдварыг бадрааж, урам зоригийг сэргээсэн үйл явдал болсон билээ.

ШУА нь дэлхийн жишиг, дотоодын онцлогт нийцүүлэн салбарын эрхзүйн орчныг сайжруулах, эрдэм шинжилгээний байгууллагуудын бүтэц зохион байгуулалтыг боловсронгуй болгох, судалгаа, шинжилгээний ажлын зорилт, гарах үр дүнг үндэсний хэмжээний томоохон төсөл, хөтөлбөрүүдтэй уялдуулах, салбарын санхүүжилтийн механизмыг сайжруулах, гадаад харилцааг өргөжүүлэх замаар хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, боловсон хүчин бэлтгэх, чадваржуулах зэрэг асуудалд анхаарч ажилласны дүнд 13 улсын 24 байгууллагатай гэрээ, хэлэлцээр байгуулж, Олон улсын Шинжлэх ухааны байгууллагуудын холбоо (ANSO)-ны удирдах дээд байгууллагын гишүүнээр сонгогдож, дэлхийн түвшний чансаатай олон арван бүтээл туурвин, эх орныхоо хөгжил дэвшилд хувь нэмэр оруулахуйц шинэ мэдлэг бүтээж, технологи, инновацын дорвитой шийдлүүд гарган ажилласныг тэмдэглэхэд таатай байна.

Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн ерөнхийлөгч, академич Д.Рэгдэл Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан нарын байгуулсан жил бүрийн үр дүнгийн гэрээний хэрэгжилт бүрэн биелж, ШУА-ийн Их чуулган, Тэргүүлэгчдийн хурал, салбарын бага чуулган, төрөлжсөн академиудын үйл ажиллагааны ажил хэрэгч чанар дээшилж, тодорхой асуудлуудыг тухай бүр хэлэлцэн, шийдвэрлэж ирлээ.

НЭГ. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

1.1 ЭРХЗҮЙН ОРЧНЫ ТАЛААР

Тайлант хугацаанд Монгол Улсын шинжлэх ухаан, технологи, инновацын салбарт Шинжлэх ухаан, технологийн тухай хууль, Инновацын тухай хууль, Шинжлэх ухаан, технологийн болон Инновацын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл, Шинжлэх ухаан, технологийн сангаас тэтгэлэг олгох, сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журам, Олон улсын нэр хүндтэй мэргэжлийн эрдэм шинжилгээний сэтгүүлд бүтээл нийтлүүлсэн судлаачдад мөнгөн урамшуулал олгох журам зэрэг 20 орчим хууль тогтоомж, дүрэм, журамд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг УИХ-аар батлуулах, шинжлэх ухаан, технологийн салбарын бүтэц зохион байгуулалтыг боловсронгуй болгох асуудлаар Засгийн газрын шийдвэр гаргуулах, төрийн өмчийн эрдэм шинжилгээний хүрээлэн, төвийн судалгааны үндсэн чиглэлийг тодорхойлох, суурь судалгааны төслийг хүрээлэнгийн тэргүүлэх чиглэлтэй уялдуулах, салбар хоорондын болон салбар дамнасан судалгааг хэрэгжүүлэх, суурь болон хэрэглээний судалгааны зохистой харьцааг тогтоох, хүрээлэнгийн үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийн судалгаанд хөрөнгө оруулалт судалгааны лабораториудын чадавхыг дээшлүүлэх, барилга байгууламж, тоног төхөөрөмжийн шинэчлэлийг эрчимжүүлэх, олон улсын болон хамтарсан төсөл, хөтөлбөрийн тоог нэмэгдүүлэх, үр өгөөжийг өргөжүүлэх, санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэх болон ШУА-ийн хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, оюуны өмчийн бодлогын хэрэгжилтийг хангах, инновацын хүний нөөцийг сургах, бэлтгэх, чадавхжуулах, стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах зэрэг томоохон зорилтыг дэвшүүлэн ажиллав.

Сүүлийн жилүүдэд төр засгийн зүгээс үндэсний шинжлэх ухааны салбарын хөгжилд анхаарах чиг хандлага нэлээд өөрчлөгдсөний дүнд ШУА нь дэлхийн жишиг, дотоодын онцлогт нийцүүлэн салбарын эрхзүйн орчныг сайжруулахад чиглэгдсэн томоохон алхмуудыг хийхэд идэвхийлэн оролцож ирлээ. Үүний дүнд салбарын суурь хууль болох Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийг УИХ-аар шинэчлэн батлуулж, судалгаа, шинжилгээний ажлын зорилт, гарах үр дүнг үндэсний хэмжээний томоохон төсөл, хөтөлбөрүүдтэй уялдуулах, салбарын санхүүжилтийн механизмыг сайжруулах зорилгоор Монгол Улсын шинжлэх ухаан технологийг хөгжүүлэх тэргүүлэх чиглэл, цөм технологийг тодорхойлох журам, Төрийн өмчит эрдэм шинжилгээний хүрээлэн, төвийн судалгааны үндсэн чиглэлийг тодорхойлох, санхүүжүүлэх журам, Шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэл, цөм технологийн жагсаалт (2023-2026)-ыг тус тус Засгийн газрын тогтоолоор шинэчлэн батлууллаа. Эдгээр эрх зүйн орчны шинэчлэл болон төрийн албаны эрх зүйн орчны шинэчлэлтэй уялдуулан салбарын менежментийг сайжруулах чиглэлээр ШУА-ийн харьяа хүрээлэнгийн захирлыг сонгон шалгаруулж томилох чөлөөлөх журам, ШУА-ийн харьяа хүрээлэнгийн захирлын албан тушаалын тодорхойлолт, ШУА-ийн Тэргүүлэгчдийн газрын Хөдөлмөрийн дотоод журам, ШУА-ийн харьяа хүрээлэнгийн захирлын үр дүнгийн гэрээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг үнэлэх аргачлал, Эрдэм шинжилгээний байгууллага, ажилтанд грант олгох журмыг тус тус шинэчлэн батлав.

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль шинээр батлагдсантай холбогдуулан Эрдэм шинжилгээний ажилтны ёс зүйн дүрмийг шинэчлэн баталж, ШУА-ийн дэргэд ажиллах ёс зүйн дэд хороог байгуулж түүний ажиллах журмыг батлан гаргалаа. Түүнчлэн ШУА-ийн харьяа эрдэм шинжилгээний хүрээлэнгийн судлаачдаас олон улсын нэр хүндтэй мэргэжлийн сэтгүүлд бүтээл хэвлүүлсэн тохиолдолд мөнгөн урамшуулал олгох эрх зүйн орчныг бүрдүүлж чадсан нь судлаачдын судалгааны ажлын үр дүнг үнэлэхэд чиглэгдсэн эрх зүйн орчныг бүрдүүлсэн гэж үзэж байна. Тайлант хугацаанд салбарын эрхзүйн орчныг сайжруулах чиглэлээр гарсан хууль, тогтоомжийн шийдвэрүүдийг тоймлон харуулбал:

Монгол Улсын Их Хурлаас:

2024 оны 5 дугаар сард Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталсан. Шинжлэх ухаан, технологийн тухай шинэчилсэн хуульд хүний амьдралын чанар, нийгэм, эдийн засгийн болон шинжлэх ухаан, технологийн хөгжил, улсын үндэсний аюулгүй байдлыг хангахад чиглэсэн зарим шаардлагатай нэр томъёог шинэчлэн тодорхойлж, шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх, эрдэм шинжилгээний байгууллага, үндэсний судалгаа хөгжүүлэлтийн төсөл болон суурь шинжлэх ухаан, хувийн хэвшлийн судалгааг дэмжих, шинжлэх ухаан технологийн дотоодын болон олон

улсын хамтын ажиллагааг зохицуулах, санхүүжилтийн механизмыг сайжруулах зэрэг олон чухал заалтуудыг нэмснээр шинжлэх ухаан, технологийн бодлого, урт болон дунд хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан зорилтуудыг үр дүнтэй хэрэгжүүлэх хууль, эрх зүйн орчин бүрдээд байна.

Монгол Улсын Засгийн газраас:

- Монгол Улсын шинжлэх ухаан технологийг хөгжүүлэх тэргүүлэх чиглэл, цөм технологийг тодорхойлох журам (Засгийн газрын 2022 оны 183 дугаар тогтоол);
- Төрийн өмчит эрдэм шинжилгээний хүрээлэн, төвийн судалгааны үндсэн чиглэлийг тодорхойлох, санхүүжүүлэх журам (Засгийн газрын 2022 оны 409 дүгээр тогтоол);
- Шинжлэх ухаан, технологийн сангаас тэтгэлэг олгох, сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журам (Засгийн газрын 2022 оны 497 дугаар тогтоол);
- Гарааны компани болон программ хангамжийн үйлдвэрлэл, хөгжүүлэлтийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжид дэмжлэг үзүүлэх журам (Засгийн газрын 2023 оны 39 дүгээр тогтоол);
- Шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэл, цөм технологийн жагсаалт (2023-2026) (Засгийн газрын 2023 оны 249 дүгээр тогтоол) зэргийг батлан мөрдүүлж байна.

Боловсрол, шинжлэх ухааны яамнаас:

- Эрдэм шинжилгээний ажилтны ёс зүйн дүрэм (Сайдын 2023 оны А/156 тушаал);

ШУА-ийн Тэргүүлэгчдийн хурлаас:

- ШУА-ийн харьяа хүрээлэнгийн захирлыг сонгон шалгаруулж томилох чөлөөлөх журам (Тэргүүлэгчдийн 2021 оны 01 дүгээр сарын 14–ний 02 дугаар тогтоол);
- ШУА-ийн харьяа хүрээлэнгийн захирлын албан тушаалын жишиг тодорхойлолт (Тэргүүлэгчдийн 2021 оны 01 дүгээр сарын 14–ний 01 дүгээр тогтоол);
- Эрдэм шинжилгээний байгууллага, ажилтанд грант олгох журам (Тэргүүлэгчдийн 2024 оны 01 дүгээр сарын 01–ний 04 дүгээр тогтоол);

ШУА-ийн Ерөнхийлөгчийн тушаалаар:

- Дотоодын мэргэжлийн эрдэм шинжилгээний сэтгүүлийн жагсаалт (2022 оны А/14 дугаар тушаал);
- ШУА-ийн ёс зүйн дэд хорооны ажиллах журам (2023 оны А/202 дугаар тушаал);
- Олон улсын нэр хүндтэй мэргэжлийн эрдэм шинжилгээний сэтгүүлд бүтээл нийтлүүлсэн судлаачдад мөнгөн урамшуулал олгох журам (2023 оны А/231 дугаар тушаал);
- ШУА-ийн Тэргүүлэгчдийн газрын Хөдөлмөрийн дотоод журам (2023 оны А/230 дугаар тушаал);
- Гадаадтай хамтарсан төсөл хэрэгжүүлэх, санхүүжүүлэх, хяналт тавих журам (2024 оны А/39 дугаар тушаал);
- Дотоодын мэргэжлийн эрдэм шинжилгээний сэтгүүлд тавигдах нийтлэг шаардлага, шалгуур үзүүлэлт (2024 оны А/44 дугаар тушаал);
- ШУА-ийн харьяа хүрээлэнгийн захирлын үр дүнгийн гэрээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг үнэлэх аргачлал (2024 оны А/125 дугаар тушаал).

Үр дүн, ач холбогдол: Шинэ мэдлэг бүтээх, хэрэглээнд нэвтрүүлэх, нийгмийг соён гэгээрүүлэх, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, менежментийг сайжруулах, байгууллагын соёлыг төлөвшүүлэх зэрэг олон чиглэлээр ШУА-ийн хэмжээнд бодитой ахиц дэвшил гарчээ. Бодлого, эрх зүй, материаллаг орчныг сайжруулахад санаачилгатай, идэвхтэй оролцох, Монгол Улсын Ерөнхийлөгчийн “100 жил – 10 зорилт” санаачилга, “Тэрбум мод” үндэсний хөтөлбөр, Монгол Улсын Засгийн газрын “Шинэ сэргэлт”-ийн 6 багц зорилт, БШУ-ы сайдын “Шинжлэх ухааны салбарыг хөгжүүлэх 5 чиглэл бүхий төлөвлөгөө” зэрэгт тулгуурлан салбарын хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, менежментийг сайжруулах, судалгааны ажлын үр дүнгээр инновацын шинэ бүтээгдэхүүн бий болгох ажлыг эрчимжүүлэх, ШУА-ийн үйл ажиллагаанд

оролцогч талуудын ажлын уялдаа холбоог дээшлүүлэх зорилт тавьж, бодлого, хөрөнгө санхүү зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлжээ.

Шинжлэх ухаан, технологийн салбарт хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 299 дугаар тогтоолоор **ШУА-ийн харьяанд Тархи, сэтгэл судлалын хүрээлэнг шинээр, Технологийн инкубаторыг сэргээн байгуулав.**

Шинжлэх Ухааны Академийн гишүүний нэмэгдлийн хэмжээг шинэчлэн тогтоох эрх зүйн үндэслэлийг боловсруулж, Сангийн сайд, БШУ-ы сайдын хамтарсан тушаалаар нэмэгдлийн хэмжээг шинэчлэн тогтоох асуудлыг шийдвэрлүүлэв.

1.2 УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР

ШУА-ийн Тэргүүлэгчдийн хурал

Сүүлийн 4 жилд ШУА-ийн Тэргүүлэгчид 21 удаа хуралдаж, ШУА-ийн Их чуулганы тов, хэлэлцэх асуудлыг тогтоох, ШУА-ийн харьяа хүрээлэнгийн захирлын албан тушаалын жишиг тодорхойлолтыг батлах, ШУА-ийн харьяа хүрээлэнгийн захирлыг сонгон шалгаруулж томилох, чөлөөлөх журмыг шинэчлэн батлах, нэмэлт өөрчлөлт оруулах, ШУА-ийн харьяа хүрээлэнгүүдийн бүтэц, эрдмийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах, ШУА-ийн Тэргүүлэгчдийн газрын бүтэц, орон тоог шинэчлэн батлах, ШУА-ийн дээд шагнал “Хубилай хаан” медальд нэр дэвшүүлэх, ШУА-ийн Хүндэт доктор цолд нэр дэвшүүлэх, Шинжлэх ухааны менежментийн мэдээллийн системийн техникийн ерөнхий даалгаврыг батлах, ШУА-ийн брэнд ном бүтээх, ШУА-ийн грантаар хэрэгжүүлэх төслүүдийг батлах, ШУА-ийн гишүүн сонгох шинжлэх ухааны салбар, чиглэл, тоог тогтоох, ШУА-ийн гишүүнд нэр дэвшигчдийн бүтээлд үнэлэлт өгөх ажлын хэсэг томилох, ШУА-ийн дунд хугацааны стратеги төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулах, Залуу судлаачдад олгодог Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит шагналд нэр дэвшүүлэх, ШУА-ийн харьяа хүрээлэнгүүдийн захирлын оны ажлын тайланг хэлэлцэх, Эрдэм шинжилгээний байгууллага, ажилтанд грант олгох журмыг шинэчлэн батлах зэрэг асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн байна.

Мөн ШУА-ийн Тэргүүлэгчдийн хурлаар Газарзүй, гео-экологийн хүрээлэнгээс боловсруулсан “Монгол Улсын Нийгэм, эдийн засгийн хөгжлийн орон зайн төлөвлөлт, шийдлийн хувилбар”, Биологийн хүрээлэнгээс боловсруулсан “Хэрэглээний биотехнологийн төв байгуулах” зэрэг асуудлыг хэлэлцэн, төслүүдийн саналыг дэмжиж холбогдох эрх бүхий байгууллагуудад хүргүүлж, Төрийн бодлого шийдвэр гаргахад шинжлэх ухааны судалгааг үндэслэх асуудлыг эрчимжүүлж бүсчилсэн хөгжлийн бодлого боловсруулахад тус судалгаанууд чухал үүрэг гүйцэтгэлээ.



ШУА-ийн Тэргүүлэгчдийн хурал

ШУА-ийн Их чуулган

2021-2024 онд ШУА-ийн Их чуулган 8 удаа чуулж, Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн эрхзүйн байдлын тухай хуульд заасан үүргийнхээ дагуу ШУА-ийн эрдэм шинжилгээ, үйл ажиллагааны тайлангууд хэлэлцэн, дүгнэх, ШУА-ийн гишүүний 2 удаагийн ээлжит сонгууль, Монгол Улсын Шинжлэх Ухааны Академи байгуулагдсаны түүхт 60 жилийн ойд зориулсан “Жарнаар өртөөлсөн хөгжлийн түүхчээ” илтгэл, Монгол Улсын төр, нийгмийн нэрт зүтгэлтэн, ШУА-ийн 3 дахь ерөнхийлөгч, академич Намсрайн Содномын мэндэлсний 100 жилийн ойд зориулсан “Академич Намсрайн Содном ба Монгол Улсын шинжлэх ухаан” илтгэл, Монгол Улсын ШУА-ийн Дэд ерөнхийлөгчийн нөхөн сонгууль зэрэг үндсэн асуудлыг хэлэлцэн шийдвэрлэв.

Их чуулганаар ШУА-ийн эрдэм шинжилгээ, үйл ажиллагааны 2021-2023 оны тайлангуудыг хэлэлцүүлэн, гишүүдийн гаргасан санал, зөвлөмжийг тайланд тусган хэвлүүлж, холбогдох төр засгийн болон эрдэм шинжилгээний байгууллагууд, их, дээд сургуулиудад хүргүүлэв.

ШУА-ийн гишүүний ээлжит сонгуулийг 2 удаа зохион байгуулж, 2021 онд шинжлэх ухааны доктор Ц.Батбаяр, Ж.Даваасамбуу, Ц.Нанзад, Ж.Норовсүрэн, Н.Тогтохбаяр нар, 2022 онд Б.Батхишиг, Ч.Ган-Өлзий, Ч.Чимэдрагчаа, Р.Энхбат, Д.Энхтуяа нар ШУА-ийн гишүүнээр тус тус сонгогдож, академич хэргэм хүртэв.

Монгол Улсын ШУА-ийн гадаад гишүүнээр ОХУ-ын Ломоносовын нэрэмжит Москвагийн Улсын Их сургуулийн Газарзүйн факультетын ерөнхийлөгч, Оросын газарзүйн нийгэмлэгийн тэргүүн дэд ерөнхийлөгч, академич Николай Сергеевич Касимов, Япон улсын Осака олон улсын Их сургуулийн хүндэт профессор, доктор Койчи Мацуда нар сонгогдлоо.

Монгол Улсын ШУА-ийн дэд ерөнхийлөгчийн нөхөн сонгуулийг Их чуулганы хуралдаанаар холбогдох журмын дагуу 2023 оны 12 дугаар сарын 21-ний өдөр явуулж, шинжлэх ухааны доктор, профессор Цэгмэдийн Цэрэндоржийг сонгов.



ШУА-ийн Их чуулганы хуралдаан

ШУА-ийн салбарын Бага чуулган, төрөлжсөн Академиуд

Салбарын бага чуулган, төрөлжсөн Академиуд сүүлийн 4 жилд 80 гаруй удаа хуралдаж, үйл ажиллагааны тайлан, төлөвлөгөө хэлэлцэж багтах, ШУА-ийн гишүүнд нэр дэвшүүлэх, Монгол Улсын Төрийн шагналд болон Шинжлэх ухаан, технологийн салбарын шагналд бүтээл дэвшүүлэх, хэрэгжүүлж дууссан суурь судалгааны төслийн тайлан хэлэлцэн, дүгнэлт гаргах, Бага

чуулганы дарга, орлогч даргыг сонгох, ШУА-ийн Их чуулганы гишүүний сонгуульд нэр дэвшүүлэх квот, мэргэжлийн чиглэлийг тогтоох, салбарын шинжлэх ухааны хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлийг тогтоох, дотоодын мэргэжлийн эрдэм шинжилгээний сэтгүүлийн жагсаалтыг гаргах, зөвлөмж боловсруулах зэрэг асуудлыг хэлэлцэн шийдвэрлэв.

ШУА-ийн салбарын бага чуулган үүсгэн байгуулагдсаны 25 жилийн ой, “Шинжлэх ухааны ажилтны өдөр”-ийг тохиолдуулан “Монгол Улсын шинжлэх ухаан, технологийн хөгжилд салбарын бага чуулган, төрөлжсөн академиудын гүйцэтгэх үүрэг, тулгамдсан асуудал, шийдэл” сэдэвт эрдэм шинжилгээний хурлыг 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр зохион байгуулав.


ШУА-ийн салбарын бага чуулган, төрөлжсөн академиуд 2021-2024 онд хэрэгжиж дууссан 196 суурь судалгааны төслийн тайлан хэлэлцэн, холбогдох дүгнэлтийг БШУЯ болон ШУТС-д хүргүүлсэн ба нийт 376 эрдэмтэн мэргэжлийн шинжээчээр ажиллан, дүгнэлт гаргасан байна.

ШУА-ийн дүрэм, ШУА-ийн Бага чуулганы дүрэм зэрэг эрх зүйн баримт бичгүүд шинэчлэгдэн батлагдсантай холбоотойгоор ШУА-ийн салбарын бага чуулганы гишүүний сонгууль явуулж, сонгуулиар 6 бага чуулганд 47 мэргэжлийн чиглэлээр 106 эрдэмтэн гишүүнээр сонгогдов. ШУА-ийн Бага чуулганы дүрмийн 2 дугаар зүйлийн 7 дахь заалтын дагуу 19 эрдэмтэн салбарын 6 бага чуулганы төрийн төлөөллийн гишүүнээр батлагдав.

Тайлант хугацаанд ШУА-ийн салбарын бага чуулган, төрөлжсөн Академиудаас 2021-2024 онд Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, УИХ-ын Тамгын газар, Засгийн газар болон бусад холбогдох Төрийн болон олон улсын байгууллагуудтай хамтран Ардын хувьсгалын 100 жилийн ойд зориулсан “1921 оны Ардын хувьсгал -100 жил, түүх ба орчин үе”, “Вирус судлалын тулгамдсан асуудал”, “Газрын доорх дулааны болон цэвэр усны шугамын техникийн байдлыг оношлоход металлын соронзон санамжийн аргыг хэрэглэх боломж”, “Мэргэжлийн холбоо, нийгэмлэгийн үйл ажиллагаа дахь ШУА-ийн оролцоо, хамтын ажиллагаа”, “Эрдэм шинжилгээний нээлттэй мэдээллийн сан хөгжүүлэлтийн өнөөгийн боломж ба шийдэл: Нийгэм, хүмүүнлэгийн салбарын жишээнд дээр”, “Эрдэм шинжилгээний сангийн цахим хувилбар хөгжүүлэлт ба сэтгүүлийн цахим шилжилт, туршлага ба сорилт”, “Цахим толь бичгийн боловсруулалт, хөгжүүлэлт”, “Дээд боловсролын цахим шилжилтийн өнөөгийн байдал, цаашдын зорилтууд”, “Цахим шилжилтийн олон улсын туршлага: Австри улсын жишээгээр”, “Эрчим хүчний эх үүсгүүр-Алтернатив эрчим хүч”, “Нийгэм, улс төр, эдийн засгийн тулгамдсан асуудал: Гарц, шийдэл”, “Мөөг-Хүнсний хангамж, аюулгүй байдал” зөвлөгөөн, “Хөрс-хүнс-хүн тойрсон асуудал, шийдэл”, “Монгол орны ундны усны чанарын судалгаа- Ногоон хөгжлийн сэргэлт”, “Эрүүл Монгол хүн” үндэсний чуулган, “Эрүүл Монгол хүн” өдөрлөг, “Евразийн хөдөө аж ахуйн хөгжилд шинжлэх ухааны гүйцэтгэх үүрэг”, “Газрын ховор элементийн судалгаа-Аж үйлдвэржилтийн сэргэлт”, “ХАА-н тоон технологийн шилжилт ба органик үйлдвэрлэл”, “Евразийн хөдөө аж ахуйн хөгжилд шинжлэх ухааны гүйцэтгэх үүрэг”, “Газрын тос ба метан хийн судалгаа, хэтийн төлөв”, “Түрэгийн хаант улс ба өнөөгийн Турк” хэлэлцүүлэг, “Алтай дамнасан тогтвортой байдлын яриа хэлэлцээ” олон улсын чуулга уулзалт, Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүхийн ивээл дор “Шинжлэх ухаанчаар сэргэн хөгжье” Шинжлэх ухааны ажилтны II их хурал, “Монголын эрчим хүчний систем ба цөмийн эрчим хүчийг ашиглах боломж” үндэсний эрдэм шинжилгээний хурал, МОРИН ХУУР - 2024” эрдэм шинжилгээний хурал зэрэг 20 гаруй эрдэм шинжилгээний хурал, хэлэлцүүлэг зохион байгуулж, хурлаас гарсан зөвлөмжийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын Газар, УИХ, Засгийн газар болон холбогдох байгууллагуудад хүргүүлсэн байна.

Зохион байгуулсан зарим томоохон арга хэмжээнүүд:

Монгол Улсад Шинжлэх ухааны салбар үүсэж хөгжсөний 100 жилийн түүхт ойг тэмдэглэх тухай Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 250 дугаар тогтоол, ШУА-ийн Тэргүүлэгчдийн хурлын 2020 оны 7 дугаар тогтоол болон БШУЯ-аас баталсан төлөвлөгөөний дагуу манай эрдэмтэн, судлаачид “Монгол Улсын шинжлэх ухааны түүх” таван боть бүтээл, түүхэн үйл явдлыг товчоолсон “Шинжлэх ухааны хроник” бүтээл, “Монгол Улсад Эрүүл мэндийн алба үүсэж, хөгжсөний 100 жилийн түүхэн товчоон”, “Монгол Улсад орчин цагийн анагаах ухаан үүсэж, хөгжсөний 100 жилийн түүхэн товчоон” 2 боть бүтээл, БШУЯ-тай хамтран “Шинжлэх ухаан 100” сэтгүүлийг 8 дугаараар хэвлэн нийтэлж, нийтийн хүртээл болгов.



ШУА-ийн 60 жилийн түүхт ойг тэмдэглэн өнгөрүүлэх төлөвлөгөөний хүрээнд Монгол Улсад орчин цагийн шинжлэх ухааны салбар үүсэж хөгжсөний түүхт 100 жилийн ойн “Шинжлэх ухаан-100” хүндэтгэлийн хурлыг 2021 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр БШУЯ, ШУТС зэрэг байгууллагуудтай хамтран зохион байгуулж, “Шинжлэх ухаан технологийн үзэсгэлэн-100”, “Виртуал музей”-н нээлт зэргийг зохион байгуулан, Монгол шуудан ХК-тай хамтран “Орчин цагийн шинжлэх ухааны 100 жил” сэдэвт марк гаргав.

Шинжлэх ухааны ажилтны анхдугаар их хурлын шийдвэрийн хэрэгжилтийн тайланг гарган, танилцуулж, Шинжлэх ухааны ажилтны хоёрдугаар их хурлыг 2024 оны 5 дугаар сарын 14-16-ны өдрүүдэд Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, БШУЯ, ШУТС-тай хамтран Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүхийн ивээл дор “Шинжлэх ухаанчаар сэргэн хөгжсө” уриан дор зохион байгуулав. Тус II их хурлын хүрээнд “Шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлого”, “Шинжлэх ухаан, технологийн салбарын хүний нөөцийн хөгжил”, “Шинжлэх ухаан, технологийн санхүүжилт, дэд бүтэц”, “Шинжлэх ухаан, технологийн хамтын ажиллагаа” сэдэвт салбар хуралдаануудыг үр дүнтэй зохион байгууллаа.



Сүүлийн жилүүдэд улс орны хөгжлийн нэн тулгамдсан хэрэгцээ, бүрдсэн эрх зүйн орчин, олон улсын нийтлэг жишиг, ШУА-ийн нөөц боломж зэргийг харгалзан гол төлөв өндөр хөгжилтэй орнуудад докторын зэрэг хамгаалсан залуу эрдэмтэд санаачлан ахисан түвшний Их сургууль байгуулах тухай тодорхой санал боловсруулан олон түвшинд хэлэлцүүлсний үр дүнд Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн 214 дугаар тогтоолоор ШУА болон эрдэм шинжилгээний хүрээлэнгүүдийн материаллаг бааз, хүний

нөөцийг түшиглэсэн Шинжлэх Ухааны Академийн Их сургууль (UMAS) байгуулагдаж, энэ оны 6 дугаар сарын 6-ны өдөр сургуулийн нээлтийн арга хэмжээг зохион байгууллаа.

“УИХ, Ерөнхийлөгч, Засгийн газарт улс орны нийгэм, эдийн засгийн асуудлаар санал, зөвлөмж боловсруулж, хүргүүлэх” зорилтыг хангах хүрээнд Монгол Улсын Ерөнхийлөгчид “Эрчим хүчний аюулгүй байдал”-ын талаар санал, Шинжлэх ухаан, технологи, инновацын салбарын өнөөгийн байдал, тулгамдсан асуудлын талаар болон Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлан хэрэгжүүлж буй үндэсний төсөл, хөтөлбөрүүд дэх ШУА, харьяа хүрээлэнгүүдийн оролцоо, цаашид хэрэгжүүлэх боломжтой ажлуудын талаарх танилцуулга, “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд бүх аймаг, сумын төвүүдийн ногоон байгууламжид тарих ургамлын сонголтын зөвлөмж зэргийг боловсруулан хүргүүлэв.

ШУА-ийн харьяа хүрээлэнгүүдэд Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд нийт 43 чиглэлийн ажил хийгдсэн байна. Тухайлбал, Боомтын сэргэлтийн хүрээнд 7, Эрчим хүчний сэргэлтийн хүрээнд 2, Аж үйлдвэржилтийн сэргэлтийн хүрээнд 11, Хот, хөдөөгийн сэргэлтийн хүрээнд 13, Ногоон хөгжлийн сэргэлтийн хүрээнд 10 багц ажил хийгдсэн бөгөөд товч тайланг гарган БШУЯ-нд хүргүүлсэн болно.

Монгол Улсын Ерөнхий сайдын шинжлэх ухааны салбарын төлөөлөлтэй хийсэн уулзалтын үеэр Ерөнхий сайдын ажлын хэрэгцээнд зориулан ШУА-ийн удирдлагаас шинжлэх ухаан, технологийн салбарт болж байгаа гол үйл явдал, анхаарал татахуйц асуудлын талаар улирал тутам тойм мэдээлэл хүргэж байхаар тохиролцсоны дагуу Монгол Улсын Ерөнхий сайдад Шинжлэх ухаан, технологийн салбарын тухай тойм мэдээллийг бэлтгэж, хүргүүлэв.

“Шинжлэх Ухааны Академийн менежментийн чадавхыг бэхжүүлэх” зорилтыг хангах хүрээнд Шинжлэх ухаан, технологийн хүрээний хууль, тогтоомжийн хэрэгжилтийг ШУА-ийн хэмжээнд зохион байгуулан ажиллалаа. Монгол Улсын Шинжлэх ухаан, инновац, технологийн салбарт нийтдээ 20 гаруй хууль эрх зүйн акт хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа бөгөөд шинээр батлагдсан хууль, тогтоомж, дүрэм журмын талаарх мэдээллийг харьяа хүрээлэнгүүдэд цаг тухай бүрд нь хүргүүлэн хэрэгжилтийг хангуулан ажиллав.

ШУА-ийн харьяа хүрээлэнгүүдийн захирлуудын зөвлөгөөнийг 10 удаа зохион байгуулж, хүрээлэнгүүдийн үйл ажиллагааны тайлан, төлөвлөгөө, баримтлах чиглэл, төсвийн санхүүжилт, цахим шилжилт, шинэ сэргэлтийн бодлогод шинжлэх ухааны байгууллагуудын оролцоо, салбарын хууль, эрх зүй, бодлогын баримт бичгүүд болон шинээр батлагдсан Хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилт зэрэг асуудлыг хэлэлцэж, академийн ерөнхийлөгчийн зүгээс хүрээлэнгийн захирлуудад өгсөн үүрэг даалгаврын биелэлт, явцын талаарх мэдээллийг тухай бүр сонсож үнэлэлт, дүгнэлт өглөө.

Төр засгаас төрийн албан хаагчийн ёс зүйн хариуцлагыг нэмэгдүүлж, ёс зүйтэй төрийн албыг төлөвшүүлэн хөгжүүлэх чиглэлээр дэс дараатай арга хэмжээг авч 2023 оны 5 дугаар сард “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай” хуулийг батлан гаргасантай холбогдуулан Шинжлэх Ухааны Академи хуулийг сурталчлах ажлыг байгууллагын хэмжээнд зохион байгуулж, академи болон харьяа эрдэм шинжилгээний хүрээлэнгүүд Ёс зүйн дэд хороог байгуулан ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр холбогдох дүрэм, журмыг шинэчлэх, нэмэлт өөрчлөлт оруулах ажлыг хийж гүйцэтгэв.

Уламжлалт “ШУА-ийн грант минисимпозиум”, “Ахисан түвшний судалгааны үр дүн” зэрэг эрдэм шинжилгээний хурлуудыг жил бүр зохион байгуулж, ШУА-ийн грантаар хэрэгжүүлсэн 52 төслийн тайлан, БШУ-ы сайдын нэрэмжит докторын дараах судалгааны тэтгэлэг хүртсэн 30 залуу судлаачийн судалгааны ажлын үр дүнг хэлэлцүүлэн, хурлаас гарсан санал, дүгнэлтийг ШУТС-д хүргүүлэв.

1.3 ХҮНИЙ НӨӨЦИЙН ТАЛААР

ШУА-ийн харьяа эрдэм шинжилгээний 16 хүрээлэнд 2024 оны 9 дүгээр сарын байдлаар нийт 1114 хүн ажиллаж байгаагаас 906 нь эрдэм шинжилгээний ажилтан байна. Үүний дотор академич 32, доктор (Sc.D) 25, доктор (Ph.D) 246 ажиллаж байгаа бөгөөд 35 хүртэлх насны залуучууд нийт эрдэм шинжилгээний ажилтны 37.4 хувь, 35-аас 50 насных 44.1 хувийг эзэлж, дундаж нас 41 байна.

Эрдэм шинжилгээний ажилтны 33.4 хувь нь доктор болон түүнээс дээш эрдмийн зэрэгтэй байгаа ба 2024 оны байдлаар 211 эрдэм шинжилгээний ажилтан гадаад, дотоодын докторантурт суралцаж байна.

2021-2024 онд ШУА-ийн хүний нөөцийг бэхжүүлэх, мэргэшүүлэх зорилгоор давхардсан тоогоор 1600 гаруй албан хаагчийг 18 удаагийн сургалтад холбогдох мэргэжлийн чиглэлийн дагуу гадаад, дотоодын сургалтад хамруулсан байна. Үүнээс ШУА-ийн 185 судлаачийг гадаадын эрдэм шинжилгээний байгууллагуудад урт хугацааны болон богино хугацааны сургалтад хамруулан мэргэжил дээшлүүлэх боломжоор хангасан байна.

Сүүлийн жилүүдэд ШУА-ийн харьяа хүрээлэнгүүдийн хүний нөөцийн чадавхыг сайжруулах, докторын зэрэг хамгаалуулах ажлыг бодлогоор дэмжиж ажилласны дүнд 2021-2024 онд 33 эрдэмтэн шинжлэх ухааны доктор (Sc.D), 49 судлаач (гадаадад 24) доктор (Ph.D)-ын зэргийг амжилттай хамгаалав.

2024 оны байдлаар ШУА-ийн харьяа эрдэм шинжилгээний хүрээлэнгүүдээс 73 судлаач АНУ-ын Ратигерис Их сургууль, БНСУ-ын Шинжлэх ухаан технологийн хүрээлэн, Сөүлийн Их сургууль, ХБНГУ-ын Боннын Их сургууль, Килийн Их сургууль, Австралийн Мюрдокийн Их сургууль, Японы Нагоя, Кюсю, Осака Метрополитан Их сургууль, Каназавагийн Их сургууль, Унгар Улсын Будапешт хотын Өтвөш Лорандын Их сургууль, ОХУ-ын Москвагийн Техникийн Их сургууль, Санктпетербургийн Их сургууль, Эрхүү хотын Үндэсний Судалгааны Техникийн Их сургууль, БНХАУ-ын Шинжлэх Ухааны Академи, Польш Улсын Варшавын Их сургуулийн Дорно дахин судлалын факультет зэрэг гадаадын нэр хүндтэй Их сургууль, эрдэм шинжилгээний байгууллагад докторантурт суралцаж байна.

Шилдэг залуу судлаачдад олгодог Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит шагналд ШУА-аас нэр дэвшүүлдэг журмын дагуу жил бүр нэр дэвшүүлэн, өнгөрсөн хугацаанд 3 залуу судлаач тус шагналыг хүртлээ.

Залуу судлаачдыг дэмжих бодлогын хүрээнд жил бүр “Хүрэлтогоот” эрдэм шинжилгээний хурлыг “Байгалийн ухаан”, “Газарзүй-Геологи”, “Анагаах ухаан”, “Нийгэм-хүмүүнлэг”, “ХАА-Биотехнологи”, “Эдийн засаг-менежмент”, “Инженерчлэл-технологийн салбар” гэсэн шинжлэх ухааны 7 салбараар МЗЭХ, БШУЯ, ШУА, ШУТС болон Их, дээд сургуулиуд хамтран зохион байгуулдаг бөгөөд өнгөрсөн 4 жилийн хугацаанд нийт 10 эрдэм шинжилгээний ажилтан Боловсрол, шинжлэх ухааны сайдын нэрэмжит 4 сая төгрөгийн грантын эзэд болсон бөгөөд тус грантын санхүүжилт 2023 оноос 10 сая төгрөг болгохоор салбарын сайд шийдвэрлэсэн болно.

ШУА-ийн харьяа хүрээлэнгийн эрдэм шинжилгээний залуу ажилтнуудын дунд англи хэлний сургалт зохион байгуулж 120 гаруй эрдэм шинжилгээний ажилтныг амжилттай хамруулжээ. 2023 онд мэргэжлийн өгүүлэл бичих чадварыг нэмэгдүүлэх зорилгоор “Англи хэлний ахисан түвшний IELTS-д бэлтгэх” 80 цагийн сургалтыг 4 сарын хугацаатай “Сантис” сургалтын төв дээр зохион байгуулж 9 хүрээлэнгийн 15 судлаачийг хамруулсан байна.

Гадаад, дотоодын их дээд сургуулиуд, судалгааны байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах, судлаачдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх зорилгоор “ШУА-д дадлагажигч (intern) хүлээн авах” хөтөлбөр боловсруулан, батлуулсан юм. Хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зорилгоор тусгай төлөвлөгөө боловсруулан, ажилласны дүнд 13 дадлагажигчийг холбогдох судалгааны чиглэлээр 5 хүрээлэнд, 3 судлаачийг ШУА-ийн Тэргүүлэгчдийн газарт тус тус хүлээн авч, ажиллууллаа.

Өнгөрсөн 4 жилийн хугацаанд ШУА-ийн харьяа эрдэм шинжилгээний хүрээлэнгүүдээс 230 орчим судлаач ХБНГУ-ын Боннын Их сургууль, Килийн Их сургууль, Австралийн Мюрдокийн Их сургууль, Японы Нагоя, Кюсю, Тохокү Их сургууль, Унгар улсын Сегедийн Их сургууль,

Израилын Хэброу Их сургууль, БНСУ-ын Сөүлийн Их сургууль, Ханкёнг үндэсний Их сургууль, Кангвон Их сургууль, ОХУ-ын Москвагийн техникийн Их сургууль, Санктпетербургийн Их сургууль, БНХАУ-ын Шинжлэх Ухааны Академи, Швейцарын Цюрихийн технологийн хүрээлэн зэрэг гадаадын нэр хүндтэй Их сургууль, эрдэм шинжилгээний байгууллагад богино хугацааны мэргэжил дээшлүүлсэн байна.

Хүний нөөцийг дэмжин ажиллах хүрээнд төрийн өмчийн 6 сургуультай хамтын ажиллагааны санамж бичгийг байгуулан зарим тодорхой ажлуудыг хийжээ. Тухайлбал, МУИС-тай байгуулсан санамж бичгийн хүрээнд ШУА-ийн харьяа хүрээлэнгүүдээс Ахисан түвшний сургуульд суралцаж буй 12 докторант эрдэм шинжилгээний багц цагийн 50%-ийн хөнгөлөлт эдлэхээр болов.

ШУА-ийн Ерөнхийлөгчийн баталсан PI&PP50 хөтөлбөрийн дагуу судлаачдын мэдлэг чадварыг дээшлүүлэх зорилгоор “Төслийн удирдагч бэлтгэх болон төслийн санал боловсруулах арга зүй эзэмшүүлэх” сургалтыг цахимаар, “Олон улсын сэтгүүлийн өгүүлэл бичих арга зүй эзэмшүүлэх” 7 удаагийн сургалтыг цахим болон танхимаар зохион байгуулж давхардсан тоогоор 16 хүрээлэнгийн 140 орчим судлаач сургалтад хамрагдав.

Судалгаа хөгжүүлэлтийн ажлын үр дүнд бий болсон бүтээгдэхүүний оюуны өмчийн хамгаалалт хийх, эдийн засгийн эргэлтэд оруулах ажлыг дэмжих зорилгоор Оюуны өмчийн газартай хамтран харьяа хүрээлэнгүүдээс 13 оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийг сургаж бэлтгэв.

Манай эрдэмтэн судлаачдын оюуны бүтээл, судалгааны ажлын үр дүнг дотоод, гадаадад өндрөөр үнэлж өнгөрсөн 4 жилд ШУА-ийн Газарзүй, гео-экологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, академич Д.Доржготов, сансрын нисгэгч, баатар Ж.Гүррагчаа нар Монгол Улсын төрийн дээд шагнал, тэргүүн зэргийн “Чингис хаан” одонгоор, академич Ч.Авдай, П.Нямдаваа, Р.Барсболд нар Монгол Улсын Хөдөлмөрийн баатар цол, академич Ж.Болдбаатар, Ц.Лхагвасүрэн, Б.Жадамба, Б.Бямбаа, Т.Дорж, Д.Дашжамц, Ж.Болдбаатар, Д.Дүнгэрдорж, доктор Б.Даш-Ёндон, Л.Дашням нар Ардын багш цол, академич Р.Шагдарсүрэн “Ардын эмч” цол, академич П.Очирбат, С.Нарангэрэл, Н.Баасанжав нар Монгол Улсын Төрийн шагналаар, академич Д.Рэгдэл, С.Батмөнх нар Сүхбаатарын одонгоор, академич Г.Чулуунбаатар, Ц.Баатар, Ч.Дугаржав, Н.Бэгз, Б.Пүрэвсүрэн, Ш.Дэмбэрэл, Т.Жанлав, С.Дэмбэрэл, Д.Сангаа, С.Чулуун, доктор С.Байгалсайхан, П.Одонмажиг, Э.Пүрэвжав, Д.Сумьяа, Б.Дагвацэрэн, Н.Хүүхэнжимээ, Ч.Чулуунжав, С.Цолмон, Ц.Баатар, Д.Шүрхүү, Д.Алтай, С.Дамдинсүрэн, Б.Сумьяабаатар, Ж.Дугаржав, Б.Цогтбаатар, Д.Найдан, Г.Очирбат, Л.Жаргалсайхан нар Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн цолоор тус тус шагнагдсан нь Монголын төр засаг шинжлэх ухааны салбарт өгч буй өндөр үнэлгээ, том итгэл, гүн хүндэтгэл хэмээн үзэж байна.

Оюун ухааны олон улсын музейг үүсгэн байгуулагч З.Түмэн-Өлзийд оньслох аргаар 3500 орчим оньсон бүтээл үйлдвэрлэж 5000 гаруй техникийн зураглал, томьёолол, тодорхойлолт боловсруулан гаргаж, зохиогчийн эрх патентаар баталгаажуулсан болон Монгол үндэсний оньсон тоглоом, наадгайн уламжлалыг хөгжүүлэхэд оруулсан хувь нэмрийг нь үнэлэн ШУА-ийн Тэргүүлэгчдийн хурлын 2023 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн шийдвэрээр Монгол Улсын ШУА-ийн “Хүндэт доктор” цол олгов.





Мөн ШУА-ийн Палеонтологийн хүрээлэнгийн ЭШТА, академич Р.Барсболдыг Япон-Монголын шинжлэх ухаан, соёлын харилцааг хөгжүүлэхэд оруулсан хувь нэмрийг өндрөөр үнэлж Япон Улсын төрийн дээд шагнал “Мандах нар” одонгийн “Сарнай цэцэг бүхий Алтан туяа” зэрэглэлийн одонгоор шагнав.

ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн захирал, доктор, дэд профессор Г.Эрэгзэний Монгол, Унгарын шинжлэх ухаан, соёлын харилцааг хөгжүүлэхэд оруулсан хувь нэмрийг өндрөөр үнэлж Унгар Улсын төрийн дээд шагнал “Хүлэг баатрын загалмай” одонгоор шагнав.

ШУА-ийн дээд шагнал “Хубилай хаан” медалиар академич Д.Баатар, Ц.Оюунсүрэн, доктор Ж.Гүррагчаа, Л.Жаргалсайхан, Б.Цогтбаатар, Х.Мөнхбаяр, Ж.Батсуурь, ШУА-ийн Ахмадын холбооны тэргүүн, доктор Ш.Чунаг, Монгол Улсын Их хурлын гишүүн, академич Д.Рэгдэл, Монгол Улсын Их Хурлын Гишүүн, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Л.Энх-Амгалан, Мал эмнэлгийн хүрээлэнгийн захирал, доктор Б.Батцэцэг, ОХУ-ын ШУА-ийн Сибирийн салбарын дарга, академич Валентин Николаевич Пармон, ОХУ-ын Дубна хот дахь Цөмийн шинжилгээний нэгдсэн институтын мэдээлэлийн технологийн лабораторийн захирлын зөвлөх, доктор И.В.Пузынин, Азийн Физикийн 23 дугаар олимпиадын хүндэт зочин, Нобелийн шагналт эрдэмтэн, физикч Константин Сергеевич Новоселов, ОХУ-ын Алс Дорнодын Улсын Их сургуулийн Байгалийн ухааны сургуулийн захирал, академич Валентин Иванович Сергиенко, Япон Улсын Каназавагийн их сургуулийн профессор Кацужи Ёшиока нарыг тус тус шагнав.



Монгол Улсын төр засгаас манай эрдмийн хамт олны хөдөлмөр бүтээлийг өндрөөр үнэлж өнгөрсөн 4 жилд шинжлэх ухааны гавьяат 28, Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон 15, Алтангадас 29, Хөдөлмөрийн хүндэт медаль 22 эрдэмтэн тус тус шагнасан байна.

Монгол Улсын болон гадаадын 5 хүртэл иргэнд 5 жилд нэг удаа олгодог академич Б.Ринчений нэрэмжит шагналыг академич Л.Болд, доктор О.Шинэбаяр, Монгол Улсын болон гадаадын 3 хүртэл иргэнд 3 жилд нэг удаа олгодог академич Ц.Дамдинсүрэнгийн нэрэмжит шагналыг доктор Г.Билгүүдэй, академич Б.Ширэндэвийн нэрэмжит шилдэг менежерийн шагналыг Одон орон, геофизикийн хүрээлэнгийн захирал, академич С.Дэмбэрэл нар, академич Д.Сангаа, доктор Э.Уянга нарын “Соронзон”, академич Г.Чулуунбаатар нарын “Монгол Улсын



Үндсэн хуулийн үзэл баримтлал ба тогтвортой хөгжлийн бодлогын хэрэгжилт” нэгэн сэдэвт хамтын бүтээлүүд Шинжлэх ухаан, технологийн салбарын 2022 оны эрдэм шинжилгээний шилдэг бүтээлийн шагналыг тус тус хүртсэн байна.

Нэрт эрдэмтдийн ойн арга хэмжээг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд Монгол Улсын анхны мэргэжлийн философич, төр нийгмийн зүтгэлтэн, академич Д.Төмөр-Очирын мэндэлсний 100 жил, Төр, нийгэм, боловсрол, шинжлэх ухааны нэрт зүтгэлтэн, академич Н.Содномын мэндэлсний 100 жил, хэл шинжлэлийн нэрт эрдэмтэн Л.Балданы мэндэлсний 90 жил, Монгол Улсын шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, академич Дэчингунгаагийн Доржготов, Хавтгайн Намсрай, Ч.Авдай, Пунсалмаагийн Очирбат нарын 80 нас, нэр томьёо судлаач, доктор О.Адьяа, ардын аман зохиол судлаач Б.Катуу нарын 70 насны ойд зориулан ахмад эрдэмтдийн бүтээл туурвилыг мөнхжүүлэн, залуу хойч үед өвлүүлэн уламжлуулах зорилгоор үндэсний хийгээд олон улсын хэмжээний эрдэм шинжилгээний хурлууд зохион байгуулах, амьдрал үйл ажиллагаатай нь холбоотой бүтээлийн үзэсгэлэн гаргах, бүтээл, номыг нь хэвлэж нийтийн хүртээл болгох, эрдэмтний хөрөг нийтлэл бичих зэрэг олон талт арга хэмжээг зохион байгуулав.

1.4 ЛАБОРАТОРИЙН ОРЧИН, МАТЕРИАЛЛАГ БААЗЫГ БЭХЖҮҮЛЭХ ТАЛААР

Манай улсад үйл ажиллагаа явуулж байгаа лабораториудын ихэнх нь албан байгууллагын харьяанд буюу байгууллагынхаа үйл ажиллагааны хүрээнд чиглэл чиглэлээрээ ажиллаж байна.

Монгол Улсын шинжлэх ухааны байгууллага, их дээд сургууль, хувийн болон үндэсний хүрээлэн төвүүдийн дэргэд судалгааны чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 310 лаборатори байна. Үүнээс:

- Төрийн өмчит эрдэм шинжилгээний байгууллагын лаборатори /10 байгууллагын 110 лаборатори/;
- Төрийн өмчит Их сургуулийн дэргэдэх лаборатори /7 байгууллагын 103 лаборатори/;
- Яам, агентлагийн харьяа үндэсний хүрээлэн төвүүдийн лаборатори /10 байгууллагын 39 лаборатори/;
- Хувийн хэвшлийн судалгаа, туршилтын лаборатори /10 байгууллагын 22 лаборатори/;
- Хувийн их дээд сургуулийн лаборатори /6 байгууллагын 36 лаборатори/ тус тус багтаж байна.

2020 оны байдлаар улсын хэмжээнд 164 лаборатори итгэмжлэгдсэнээс их сургууль, хүрээлэнгийн харьяа 13 лаборатори (7.9%), үндэсний болон олон улсын хэмжээнд итгэмжлэгдсэн бол тухайн салбарын нээлттэй, дундын лабораторийн сүлжээнд нэгдэх боломжтой яам, агентлаг, тусгай газрын 11 лаборатори итгэмжлэгдсэн тоон мэдээлэл байна. Дээрх тоон мэдээллийг Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжсэн “Салбар дундын нээлттэй, сүлжээ лабораторийн итгэмжлэлийн техникийн шаардлага болон Судалгааны нээлттэй, дундын болон сүлжээ лабораторийн стандарт, эрх зүйн зөвлөх үйлчилгээ” сэдэвт /БСШУСЯ. АХБ-ны L2766-МО/ зөвлөх үйлчилгээний ажлын хүрээнд гарсан дүн мэдээлэл болно.

ШУА-ийн харьяа 16 хүрээлэнд байгалийн ухааны салбарын 66 лаборатори, нийгмийн ухааны салбарт 31 лаборатори тус тус ажиллаж байна. 2021 онд ШУА-ийн харьяа хүрээлэнгүүдэд ашиглагдаж байгаа болон цаашид худалдан авах шаардлагатай өндөр хүчин чадалтай багаж, тоног төхөөрөмжийн бүртгэлийг хийж, ашиглагдаж буй нийт багаж, тоног төхөөрөмж 116 байгааг тогтоов. Үүнээс 1-10 жилийн хугацаанд ашигласан өндөр хүчин чадалтай цаашид ашиглагдах 44 багаж, тоног төхөөрөмж байна. Эдгээрээс ойрын 1-2 жилд шаардлагатай 46 багаж, тоног төхөөрөмж байгаа бөгөөд үүнд 4.7 тэрбум төгрөг, 3-4 жилийн дотор шаардлагатай 19 багаж тоног төхөөрөмжид 6.2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт шаардлагатай байгааг тооцоолон гаргав.

Энэ судалгааны хүрээнд ШУА-ийн Тэргүүлэгчдийн газар болон харьяа хүрээлэнгүүд лабораторийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, багаж, тоног төхөөрөмж, худалдан авахад онцгой анхаарч ажилласны үр дүнд жил бүр 1 тэрбум гаруй төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэв.

Төрийн өмчийн 6 сургуулийн хамтын ажиллагааны санамж бичгийн хүрээнд дундын ашиглах судалгааны лабораториудыг гаргаж баталсан ШУА-аас 22 лаборатори нээлттэй ашиглах санал өгч баталгаажуулсан.

Тайланд хугацаанд ШУА-ийн харьяа ФТХ-д Фотоникийн лаборатори, Фазын шилжилт материал бүхий дулаан хуримтлуурын системийн лаборатори, ТССХ-д Молекул, системийн нейросайнсийн салбар, Эмнэлзүйн нейросайсын салбар, Сэтгэл судлалын салбар, Салбар дундын технологи дамжуулалт, инновацын төвийг тус тус байгуулсан байна.

1.5 ДЭД БҮТЦИЙН ТАЛААР

Удирдлагын мэдээллийн онлайн системийг хөгжүүлэх, ашиглах

ШУА-ийн бүх түвшинд удирдлагын мэдээллийн онлайн систем Динамик платформын хэрэглээг нэмэгдүүлэх, албан хэрэг хөтлөлт, ажил хэрэг төлөвлөлт, дотоод цахим мэдээллийн урсгалыг нэмэгдүүлж, бүрэн цахимжиж нийт 1190 хэрэглэгчийн бүртгэлтэй болов.

Эрдэмтэн судлаачдын судалгааны ажлын үр дүн, үнэ цэнийг нэмэгдүүлж шинжлэх ухааны болон эдийн засгийн эргэлтэд оруулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор Монголын судалгааны цахим сүлжээ-MORI төслийг хэрэгжүүлж, үндэсний мэдлэгийн дата төвийг байгуулах саналыг Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тусгуулах бэлтгэл ажлыг хангаж ажиллав. Тус платформыг хөгжүүлэн хэрэглээнд нэвтрүүлэх эхний шатыг хэрэгжүүлж ШУА-ийн Хими, химийн технологийн хүрээлэн, Археологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан судлаачдын гадаад, дотоодын бүх эрдэм шинжилгээний бүтээлийн эхийг Zotero программ ашиглан нэгтгэж, өгөгдлийг боловсруулан байршуулаад байна.

ШУА-ийн нэгдсэн дотоод сүлжээний тоног төхөөрөмжийн өргөтгөл, шинэчлэлийг хийж, үндсэн зангилааны 16 ухаалаг сүлжээний төхөөрөмжийн худалдан авч, сүлжээний бүтцийг шинэчлэн зохион байгуулж, суурилуулах ажлыг хэрэгжүүлж дууслаа. Үүний үр дүнд дотоод сүлжээний үйл ажиллагааны найдвартай байдал хангагдан, мэдээлэл дамжуулах хурд 1 гигабит хүртэл нэмэгдэх нөхцөл бүрдлээ. Дээрх бэлтгэл ажлыг хангаснаар Шинжлэх Ухааны Академийн гадаад интернэтийн үйлчилгээний хурдыг нэмэгдүүлэх боломж бүрдэж, 2020 онд 100 mbps хурдтай байсан интернэтийн үйлчилгээг 270 mbps болгон нэмэгдүүллээ.

2024 онд ШУА-ийн болон харьяа хүрээлэнгүүдийн цахим хуудсыг Монгол хэл, Англи хэл, Монгол бичгийн гурван хэлний сонголттой компонент бүтэцтэй байхаар нэгдсэн цахим хуудасны загварыг шинэчлэв.

ШУА-ийн брэнд ном

ШУА-ийн Брэнд номыг бүтээлгэж хэрэглээнд нэвтрүүллээ. Номын болон 3D загварын эх файлыг цахимд байршуулав.

Шинжлэх ухааны хүрээлэнгүүдийн нэгдсэн цогцолбор

Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтад “ХП.4.1.3 Шинжлэх ухаан, инновацын төвийн кластер /Улаанбаатар/, 2020-2022” ажлыг улсын төсвөөс 94.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэйгөөр, 2020 онд 3.0 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэйгээр анх батлагдсан юм. Шинжлэх ухаан, инновацын төвийн кластер нэрийг 2022 онд өөрчилж, Шинжлэх ухааны хүрээлэнгүүдийн нэгдсэн цогцолбор болгосон.

Шинжлэх ухаан, технологи, инновац, танин мэдэхүйн үйл ажиллагаа эрхлэх, олон улсын стандартад нийцсэн нээлттэй, салбар дундын, төрөлжсөн лаборатори, технологи дамжуулах төв бүхий 7 хэсэг бүхий 74,000 м² талбай бүхий барилга байгууламжаас бүрдсэн Шинжлэх ухааны хүрээлэнгүүдийн нэгдсэн цогцолбор нь Улаанбаатар хот, Баянзүрх дүүргийн 12 дугаар хорооны нутаг дэвсгэрт Шинжлэх Ухааны Академийн эзэмшлийн 4.8 га талбайд баригдаж байна.

Тус цогцолборт Шинжлэх Ухааны Академи түүний харьяа эрдэм шинжилгээний 16 хүрээлэн, Шинжлэх ухаан, технологийн сан, Шинжлэх ухааны паркийн захиргаа, Анагаах ухааны хүрээлэн зэрэг эрдэм шинжилгээний байгууллагууд үйл ажиллагаагаа явуулахаар төлөвлөж зураг төсвийг нь боловсруулсан юм. Цогцолборын барилгын ажлыг 2020 оны 10 дугаар сард эхлүүлж 3.0 тэрбум төгрөг, 2021 онд 24.0 тэрбум төгрөг, 2022 онд 21.1 тэрбум, 2023 онд 20.7 тэрбум, 2024 онд 27.7 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгоод байна. Одоогийн байдлаар 5 барилгын ажил төлөвлөгөөний дагуу хэвийн явагдаж, 27,000 м² ашиглалтын талбай бүхий лабораторийн 3 гол объектыг 2024 оны 4 дүгээр улиралд багтаан ашиглалтад оруулахаар холбогдох газруудтай хамтран ажиллаж байна.

Засвар үйлчилгээний цех

Шинжлэх ухааны хүрээлэнгүүдийн нэгдсэн цогцолборын барилга, байгууламжийн төлөвлөлтөд Хүрээлэн дундын засвар үйлчилгээний цехийн бүтээн байгуулалтыг иж бүрнээр тусган оруулав.



1.6 ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГАА

ШУА нь гадаад харилцааг хөгжүүлэх, харилцаа бүхий орнуудын Шинжлэх Ухааны Академиудтай байгуулсан гэрээ хэлэлцээр, хамтын ажиллагааны протокол, төлөвлөгөөг идэвхжүүлэх, зарим орны шинжлэх ухааны байгууллагуудтай шинээр харилцаа холбоо тогтоох, эрдэм шинжилгээний хамтарсан төсөл хэрэгжүүлэх, экспедиц, олон улсын хурал, семинар зохион байгуулах, эрдэмтэн солилцоог өргөтгөх, шинжлэх ухаан, технологи, инновацын чиглэлээрх мэдээллийн санг хөгжүүлэх, залуу судлаачдыг олон улсын байгууллага, Их сургуулиудын төрөл бүрийн тэтгэлэгт сургалтад хамруулах олон талт үйл ажиллагааг хэрэгжүүлж ирлээ.

Гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд

ШУА сүүлийн 4 жилийн хугацаанд 13 улсын 24 байгууллагатай 7 санамж бичиг, 3 гэрээ, 9 хэлэлцээр, 5 протокол байгуулж, 14 улсын бүрэн эрхт элчин сайд, зочид төлөөлөгчийг хүлээн авч уулзан 13 хамтын ажиллагааг шинээр эхлүүлж, олон улсын 8 байгууллагын гишүүн, удирдах зөвлөл болон Их чуулганд төлөөлөгчөөр сонгогдон ажиллаж байна. Энэ хугацаанд гадаадын 30 гаруй улсын 120 орчим байгууллагатай хамтарсан давхардсан тоогоор 350 орчим судалгааны төсөл, гадаадтай хамтарсан 6 мобилити төсөл тус тус хэрэгжүүлж, нийт 21 эрдэмтэн хүлээн авч, ШУА-ийн 12 эрдэмтнийг тэгш солилцооны хөтөлбөрөөр гадаад улсад ажиллуулж, туршлага судлуулсан байна.

Тухайлбал олон улсын Шинжлэх Ухааны Академиудаас 2023 онд Бүгд Найрамдах Польш Улсын Варшавын Их сургуулийн ректор Алози Новак, 2024 онд Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Боннын Их сургуулийн ректор, Археологийн хүрээлэнгийн захирал, Бүгд найрамдах Беларусь Улсын Үндэсний ШУА-ийн Тэргүүлэгчдийн газрын дарга, академич ГУСАКОВ Владимир Григорьевич тэргүүтэй төлөөлөгчид, Бүгд Найрамдах Болгар Улсын Шинжлэх Ухааны Академийн Ерөнхийлөгч, профессор Жулиан Пержавлски, Вьетнамын Шинжлэх ухаан, технологийн Академийн ерөнхийлөгч Чау Ван Минь тэргүүтэй төлөөлөгчид манай улсад айлчиллаа. Харин Монгол Улсын Шинжлэх Ухааны Академиас Узбекистаны Үндэсний ШУА, Чехийн ШУА, ОХУ-ын ШУА-дад айлчлал хийж Шинжлэх ухаан, технологийн салбарт хамтран ажиллах тухай гэрээ, хэлэлцээр, санамж бичигт тус тус гарын үсэг зурж, хамтын ажиллагаагаа өргөжүүллээ.



Эдгээр айлчлалын 6 нь Монгол Улсын төрийн дээд хэмжээний айлчлалын хүрээнд зохион байгуулагдсан нь Монгол Улсын төр засгаас Шинжлэх ухааны салбарт хандах хандлага өөрчлөгдсөнийг илэрхийлэх томоохон илрэл гэж дүгнэж байна.

ШУА-ийн Ерөнхийлөгч, Академич Д.Рэгдэл Олон улсын Шинжлэх ухааны зөвлөл (ISC), Олон улсын ШУА-уудын нэгдэл (ANSO)-ийн Ерөнхий Ассамблей, Түрэгийн ертөнцийн орнуудын үндэсний ШУА-ийн холбооны Ерөнхий Ассамблей, Засгийн газарт шинжлэх ухааны зөвлөгөө өгөх олон улсын сүлжээ (INGSA), Азийн Шинжлэх Ухааны байгууллагуудын холбоо (AASSA), Зүүн болон Төв Азийн Хүрээлэн буй орчны Шинжлэх Ухааны ЮНЕСКО-ийн хороо зэрэг олон улсын байгууллагуудын удирдах зөвлөх, ерөнхий ассамблейн гишүүнээр сонгогдон үйл ажиллагаанд идэвхтэй оролцон олон улсын түвшинд хэрэгжүүлж байгаа санал, санаачилгыг дэмжиж, үндэсний түвшинд буулган хэрэгжүүлэхэд анхааран ажиллаа.

Эдүгээ ШУА гадаадын 40 орчим улсын 170 гаруй эрдэм шинжилгээний хүрээлэн, Их сургуулиудтай гэрээ, хэлэлцээр, санамж бичиг, хөтөлбөр бусад төрлийн эрх зүйн баримт бичгийн хүрээнд гадаад хамтын ажиллагаа явуулж байна. Энэхүү гэрээ хэлэлцээрийг бид Монгол Улсын гадаад бодлого, Монгол Улсын шинжлэх ухаан технологийн хөгжүүлэх үндсэн чиглэл, цөм технологи, ШУА-ийн тухай байгууллагатай харилцаж ирсэн түүх, тухайн улсын шинжлэх ухаан, технологи, инновацын хөгжил зэрэгт тулгуурлан хамтын ажиллагааны Тэргүүлэх чиглэл бодлогыг гарган хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Мөн энэ жилүүдэд ШУА-ийн харьяа хүрээлэнгүүд өөрийн судалгааны чиглэлүүдийн дагуу гадаадын эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагуудтай хамтын ажиллагааны 60 гэрээ, санамж бичигт гарын үсэг зурсан нь гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх боломж нэмэгдэж буйг харуулсан үзүүлэлт юм.

Энэ хугацаанд ШУА, харьяа хүрээлэнгүүдээс нийт 185 судлаач ХБНГУ, Австри, БНСУ, Исланд, Швед, Япон, Энэтхэг, Унгар, ОХУ, БНХАУ зэрэг улсуудын Их сургууль, эрдэм шинжилгээний байгууллагуудад 1-12 сарын хугацаагаар мэргэжил дээшлүүлсэн бол 2024 оны байдлаар 74 судлаач АНУ-ын Ратигерис Их сургууль, БНСУ-ын ШУТ-ийн хүрээлэн, Сөүлийн Их сургууль, ХБНГУ-ын Боннын Их сургууль, Килийн Их сургууль, Австралийн Мюрдокийн Их сургууль, Японы Нагоя, Кюсю, Осака Метрополитан Их сургууль, Каназавагийн Их сургууль, Унгар улсын Будапешт хотын Өтвөш Лорандын Их сургууль, ОХУ-ын Москвагийн техникийн Их сургууль, Санктпетербургийн Их сургууль, Эрхүү хотын Үндэсний судалгааны техникийн Их сургууль, БНХАУ-ын Шинжлэх Ухааны Академи, Польш улсын Варшавын Их сургуулийн Дорно дахин судлалын факультет зэрэг гадаадын нэр хүндтэй Их сургууль, эрдэм шинжилгээний байгууллагад магистр, докторантурт суралцаж буй нь гадаад хамтын ажиллагааг хөшүүрэг болгон хүний нөөцийн хөгжилд жилээс жилд анхааран ажиллаж буйн илрэл юм.

Тухайлбал, АНУ-ын төрийн департаментаас зохион байгуулдаг Олон улсын зочин манлайллын хөтөлбөрийг (IVLP) Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн ерөнхийлөгчийн идэвх, санаачилгаар “АНУ-ЫН ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИ” сэдвийн хүрээнд ШУА анх удаа амжилттай зохион байгуулж, 8 хүний бүрэлдэхүүнтэй баг 2023 оны 9 дүгээр сарын 29-ний 10 дугаар сарын 21-ны хооронд хамрагдлаа. Тус баг АНУ-ын Вашингтон хотын 11, Луизиана



музейн 5, Кентаки мужийн 5, Орегон мужийн 6, нийт 27 байгууллагатай уулзалт хийж санал, туршлага солилцон хамтран ажиллах боломжийн талаар ярилцаж, уулзалт бүрээс АНУ-ын гадаад, дотоод бодлого, улс төр, Шинжлэх ухаан, технологи инновацын хөгжил, тэргүүлэх салбар чиглэл, бүтэц, зохион байгуулалт, менежмент, санхүүжилтийн тогтолцооны талаар маш чухал ойлголт мэдээллийг авч, цаашид хамтран ажиллах талаар чиглэлүүдийг тогтоож ажиллав.

Олон улсын зочин манлайллын хөтөлбөрт хамрагдсан ШУА-ийн бүрэлдэхүүн

Солонгосын Шинжлэх ухаан, технологийн хүрээлэн KIST-тэй хамтран хүний нөөцийн чадавхыг нэмэгдүүлэх зорилгын хүрээнд 2021 оноос эхлэн “Шинжлэх ухаан, технологийн бодлого боловсруулах чадавхыг бэхжүүлэх” сургалтыг 2022, 2023 онуудад 2 удаа шинжлэх ухаан технологийн салбарын 13 байгууллагын 30 хүний бүрэлдэхүүнтэй багийг 14 хоногийн богино хугацааны сургалтад хамрууллаа.



*“Шинжлэх ухаан, технологийн бодлого боловсруулах
чадавхыг бэхжүүлэх” сургалтын үеэр*

ШУА-ийн Ерөнхийлөгч Д.Рэгдэл Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Чунцин /Chongqing/ хотод болсон ANSO-ийн 3 дугаар Ерөнхий Ассамблейн хуралдаанд Биологийн хүрээлэнгийн захирал Д. Гантулгын хамтаар 2023 оны 11 дүгээр сарын 03-08-ны өдрүүдэд оролцлоо. Уг хуралд дэлхийн 72 орны 200 гаруй зочид төлөөлөгчид оролцож ANSO-ийн нийт 78 гишүүнээс удирдах зөвлөлд 6 гишүүн сонгогддог бөгөөд энэ удаад Монгол Улсын ШУА сонгогдож өдөр тутмын удирдах дээд байгууллагад нь 2024-2026 онд ажиллахаар боллоо.

Олон улсын шинжлэх ухаан, техникийн мэдээллийн төвийн (ОУШУТМТ) даргаар Монгол Улсын ШУА-ийн Ерөнхийлөгч, академич Д.Рэгдэл ажиллаж, 2023 онд Бүрэн эрхт төлөөлөгч нарын 75 дугаар хурлыг 2023 оны 06 дугаар сарын 07-08-ны өдрүүдэд цахим, танхим хосолсон хэлбэрээр Монгол Улсад зохион байгуулж түүний хүрээнд “Дижитал орчин ба эдийн засаг: шинжлэх ухаан, технологийн мэдээллийн үүрэг” сэдэвт эрдэм шинжилгээний хурлыг Шинжлэх ухаан, техникийн мэдээлэл, дижитал орчин ба эдийн засаг, Дижитал орчин ба аюулгүй хөгжил, Шинжлэх ухаан, техникийн мэдээлэл, дижиталжуулах чиглэлээр олон улсын хамтын ажиллагаа дэлхийн болон үндэсний уялдаа холбоо гэсэн 3 салбар хуралдаантайгаар зохион байгууллаа.

Гадаадын эрдэмтэн судлаачидтай холбоотой ёслолын арга хэмжээ

Нобелийн шагналтан Профессор К.С. Новоселов хатуу биеийн физик, материал судлалын чиглэлээр 380 эрдэм шинжилгээний өгүүлэл нийтлүүлсэн эрдэмтэн юм. XXI зууны технологийн хөгжилд жинтэй хувь нэмэр оруулж, аж үйлдвэрийн V хувьсгалын үндсэн “түүхий эд” болох цоо шинэ материалыг нээсэн гавьяаг үнэлж Монгол Улсад зочлох үеэр хүлээн авч хүндэтгэл үзүүлэн, Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн дээд шагнал “Хубилай хаан” медалиар шагналаа.



*Нобелийн шагналт, физикч Константин Сергеевич Новоселовт
ШУА-ийн дээд шагнал "Хубилай хаан" медаль гардууллаа.*

ОХУ-ын нэрт эрдэмтэн, тэргүүлэх зэргийн газарзүйч Н.С.Касимов Монгол Улсад орчин үеийн газарзүйн шинжлэх ухааны хөгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсныг үнэлж ШУА-ийн гадаад гишүүнээр сонгон, үнэмлэхийг гардуулан өгөв. Тэрээр Оросын газарзүйн нийгэмлэгийн Тэргүүн дэд ерөнхийлөгч, М.В.Ломоносовын нэрэмжит Москвагийн Их сургуулийн Газарзүйн факультетын ерөнхийлөгчийн албыг хашдаг. 2022 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн ШУА-ийн Их чуулганаар Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн гадаад гишүүнээр сонгосон юм.



*Оросын ШУА-ийн академич Н.С.Касимов
Монгол Улсын ШУА-ийн гадаад гишүүний үнэмлэхээ гардаж авлаа.*

Гадаадтай хамтарсан төсөл, хөтөлбөрийн талаар

2024 оны 9 дүгээр сарын байдлаар ШУА-ийн харьяа хүрээлэнгүүд гадаадтай хамтарсан нийт 52 төсөл хэрэгжүүлж байгаа бөгөөд үүнээс Археологийн хүрээлэн 10, Газарзүй, геоэкологийн хүрээлэн 23, Палеонтологийн хүрээлэн 14 төслийг тус тус хэрэгжүүлж байгаа нь гадаад харилцаа, хамтын ажиллагааны цар хүрээний өргөжилт судалгаа боловсруулалтын ажлын үр дүнг олон улсын жишигт нийцүүлэн сайжруулах улмаар олон эх үүсвэр бүхий санхүүгийн тогтолцоог бүрдүүлэх эхлэл юм.

Зарим томоохон төслүүдээс дурдвал ШУА-ийн ФТХ, МУИС, АНУ-ын Оак Риджийн Үндэсний Лаборатори, БНСУ-ын Инчоны Үндэсний Их сургууль зэрэг байгууллагуудын хамтарсан АНУ-ын Засгийн газрын 580,897 ам долларын санхүүжилт бүхий “Энергийн ялгарал ихтэй тогтмол соронзон бүтээх нано материалын дизайн болон шинж чанарын судалгаа” сэдэвт төсөл, Археологийн хүрээлэнгийн Польшийн Вроцлавын Их сургуультай хамтарсан хагас сая Еврогийн “Монгол Польшийн хамтарсан Говь цөл нутгийн өвөг, түүхийн үе” Сэдэвт төсөл зэрэг агуулга, санхүүжилт, хамтын ажиллагааны хүрээнд томоохон төслүүд хэрэгжүүлж эхлээд байна.

1.7 ДОТООД ХАМТЫН АЖИЛЛАГАА

ШУА-ийн дотоод хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор тайлант хугацаанд 20 гаруй хамтын ажиллагааны гэрээ, санамж бичиг байгуулж, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж хэрэгжилтийг ханган ажиллав.

Төр засгийн байгууллагуудтай хамтран ажилласан талаар

ШУА нь төр-шинжлэх ухаан-бизнесийн холбоог бүх шатанд хөгжүүлэх, салбар хоорондын хамтын ажиллагааг өргөтгөх зорилгоор Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, УИХ, БСШУСЯ, БОАЖЯ, ЦХХХЯ, ЭМЯ, БХБЯ, ЗТЯ, УУХҮЯ, НЗДТГ, БМИҮЗ, Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл, Архивын Ерөнхий газар, Нийслэлийн боловсролын газар, Таван Толгой ХК, UBS TV, Тогтвортой ноос, ноолуурын эвсэл, “Эрдэнэт үйлдвэр” ХХК, их дээд сургуулиуд болон орон нутгийн байгууллагуудтай хамтран улс орны нийгэм эдийн засгийн томоохон асуудлуудыг шийдвэрлэх, Засгийн газар, яамдын бодлогын хөтөлбөр, баримт бичиг боловсруулах болон захиалгат төсөл, даалгаварт ажил гэрээгээр гүйцэтгэх зэрэг олон хэлбэрээр ажиллалаа. Тодруулбал:

- Шинжлэх ухаан, үйлдвэрлэлийн хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх зорилтыг хангахад Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-тай байгуулсан хамтын ажиллагааны гэрээг шинэчлэн баталсан байна. “Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийн хүрээнд Монгол Улсад анх удаа 1000 тонн багтаамжтай ургамлын генбанк “Ойн генетик нөөцийн Эрдэнэт төв”-ийг хамтран байгуулж, үйл ажиллагааг эхлүүлээ.




Хамтын ажиллагааны үр дүнд Эрдэнэт хотын цэвэрлэх байгууламжид 40 жил хуримтлагдсан лагийг боловсруулах ажлыг 2020-2022 онд бүрэн гүйцэтгэж дуусгав. Энэ ажлын хүрээнд нийт 30,000 м.куб лагийг гумины болон биологийн идэвхт бэлдмэл ашиглан үнэргүйжүүлэн, халдваргүйжүүлж боловсруулснаар овор хэмжээний хувьд эрс багассан, техникийн нөхөн сэргээлтэд ашиглах стандартыг хангасан 6000 м.куб биобордоо-шимт хөрс үйлдвэрлэв.

-Архивын ерөнхий газартай хамтран академич Б.Чадраа, академич Ч.Цэрэн, академич Ч.Далай, академич Б.Энхтүвшин, академич Н.Содномын хувийн сан хөмрөг үүсгэх ажлыг зохион байгуулж, түүний ажил, амьдралыг өгүүлсэн товч намтар, ажил алба, шагнал, урамшуулал, сонин, хэвлэлд нийтлэгдсэн нийтлэл, өгүүлэл, эрдэм шинжилгээ, судалгааны бүтээл, тайлан, нэгэн сэдэвт ном зохиолоос бүрдсэн баримтаар хөмрөг үүсгэн, Үндэсний төв архивын сан хөмрөгийг баяжуулав.

- ЦХХХЯ-тай байгуулсан санамж бичгийн хүрээнд: Зайнаас тандан судлалын болон Холбооны хиймэл дагуулын ТЭЗҮ-гийн урьдчилсан судалгааг гүйцэтгэх ажлын хэсгүүдийг байгуулж, улмаар судалгааг гүйцэтгэн ЦХХХЯ, сансрын үндэсний зөвлөл, үндэсний аюулгүй байдлын зөвлөлд танилцуулж тайланг хүлээлгэн өгөв. Судалгаанд үндэслэн “Сансар судлалын талаар баримтлах бодлогын чиглэл”, “Сансрын тухай хууль боловсруулах хэрэгцээ шаардлагын судалгаа, хуулийн үзэл баримтлал боловсруулах” чиглэлээр ажлын хэсгүүд байгуулагдан ажиллаж байна. Эдгээр ажлын хүрээнд Сансрын техник технологи хөгжүүлэлтийн чиглэлээр

оюутан сурагчдын дунд “Кансат-2022” үндэсний тэмцээнийг зохион байгуулахад манлайлан оролцов.



Азийн Тандан Судлалын Холбоо, ЦХХХЯ, БШУЯ, Монголын Гео-Мэдээллийн Холбоо, МонМЭП ХХК-тай хамтран 18 улсын 180 гаруй эрдэмтэд оролцсон “Азийн зайнаас тандан судлалын 43-р их хурал (43th ACRS)”-ыг зохион байгуулж, хурлаас гарсан зөвлөмжийг Азийн Тандан Судлалын холбоо, ЦХХХЯ-д хүргүүлэв.

- Батлан Хамгаалах Яамтай байгуулсан санамж бичгийн хүрээнд ШУА-ийн Нийгмийн шинжлэх ухааны салбарын бага чуулганаас Зэвсэгт хүчний жанжин штаб, Үндэсний Батлан Хамгаалахын Их сургууль, Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэн, Монгол цэргийн музей, Батлан хамгаалахын төв архив, Цэргийн төв эмнэлэг зэрэг байгууллагын 60 гаруй эрдэмтэн, судлаачдыг хамруулсан туршлага солилцох 3 удаагийн өдөрлөг зохион байгуулж, ШУА-ийн харьяа хүрээлэнгүүдийн эрдэм шинжилгээ, үйл ажиллагаатай танилцуулсны дүнд салбар дундын зарим хамтарсан төслүүд хэрэгжиж эхлээд байна.

- Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын үйлчилгээг зохицуулах зөвлөлтэй хамтран Монгол Улсын 21 аймгийн 360 сум, Улаанбаатар хотын 9 дүүрэг, 128 төмөр замын дагуух зөрлөг, суурины УТБ, гүний худаг болон төвлөрсөн шугам сүлжээний 3582 уст цэгийн сорьц нэг бүрд ерөнхий физик-хими, бичил элемент, бичил амь судлал, цацрагийн аюулгүйн 88 үзүүлэлт тодорхойлов. Судалгаанд хамрагдсан уст цэгүүдээс “Унданд хэрэглэх боломжгүй” буюу хаах шаардлагатай 151, “Нэмэлт төхөөрөмж суурилуулах” шаардлагатай 606, “Нэмэлт төхөөрөмж суурилуулж, халдваргүйжилт хийх” шаардлагатай 296, “Ариутгал халдваргүйжүүлэлт хийх” буюу хэт ягаан туяа, хлоржуулах аргаар ариутгал, халдваргүйжилт хийж дахин шинжилгээнд хамруулсан тохиолдолд унданд хэрэглэх шаардлагатай 313, “Унданд шууд хэрэглэх” боломжтой 2216 уст цэгүүд байгааг тогтоон Монгол Улсын “Ундны усны нэгдсэн мэдээллийн сан”-г бий болголоо.

Орон нутгийн байгууллагуудтай хамтран ажилласан талаар

2022 оноос “Орон нутагт шинжлэх ухаан, технологи, инновацыг нутагшуулъя” аяныг БШУЯ, ШУТС-тай хамтран 11 аймагт амжилттай зохион байгууллаа. Аяны хүрээнд шинжлэх ухаан, технологи, инновацын ололтыг түгээн дэлгэрүүлэх, сурталчлах, орон нутагт тулгамдсан асуудлыг шинжлэх ухаанчаар шийдвэрлэх, технологийн боломжийг таниулах, ШУА-ийн судалгааны үр дүн, шинэ бүтээгдэхүүнийг олон нийтэд танилцуулж, Өмнөговь, Орхон, Хөвсгөл, Дархан-Уул, Ховд, Говь-Алтай, Завхан, Өвөрхангай, Төв, Сэлэнгэ, Хэнтий аймгуудтай хамтран ажиллах санамж бичиг байгуулан ажиллаж байна.



Булган аймагт



Говь-Алтай аймагт



Хэнтий аймагт




Өвөрхангай аймагт



Завхан аймагт



Төв аймагт



Өмнөговь аймагт



Хөвсгөл аймагт



Эрдэнэт хотод



Дархан-Уул аймагт

ШУА, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын хамтын ажиллагааны хүрээнд

“Хүхрийн хүчлийг ашиглан фосфорын бордоо үйлдвэрлэх туршилт судалгааны ажил /ЭҮТӨҮГ/202101822/”, “Эрдэнэт үйлдвэрийн бүсийн хөрс, усны бохирдлыг тодорхойлох” зөвлөх үйлчилгээ, “Эрдэнэтийн цэвэрлэх байгууламжийн хуримтлагдсан лагийг гумины болон биобэлдмэл ашиглан үнэргүйжүүлэх, боловсруулах” судалгааны ажил, “Булингын шахуурга” сэдэвт инновацын төсөл, “Химийн бодисын менежментийг сайжруулах” төслийг тус тус амжилттай хэрэгжүүллээ. Дээрх хамтын ажиллагааны үр дүнд үндэслэн ШУА-ийн Биологийн хүрээлэн, Эрдэнэт үйлдвэртэй “Цэвэрлэх байгууламжийн хуримтлагдсан лагийг үнэргүйжүүлэх, боловсруулах” шинэ технологи боловсруулан хамтарсан оюуны өмч мэдүүлэв.

Мөн Хангайн бүсийн мод үржүүлгийн газар байгуулах, Бүрэн автомат хүлэмжийн аж ахуй байгуулах ТЭЗҮ боловсруулж, БОАЖЯ-ны дэргэдэх ШУТ-ийн зөвлөлөөр хэлэлцүүлэн батлуулсан нь ШУА-ийн харьяа хүрээлэн хариуцаж гүйцэтгэсэн албан ёсны анхны ТЭЗҮ боллоо.

Хангайн бүсийн мод үржүүлгийн газар байгуулах, Хөрсний субстрат бэлтгэх зөвлөх үйлчилгээний ажлыг тус тус гүйцэтгэж хүлээлгэн өглөө.

Их, дээд сургуулиудтай хамтран ажилласан талаар

ШУА-ийн хүний нөөцийг чадавхжуулах ажлын хүрээнд ШУА-иас Их сургуулиудын ахисан түвшний сургалтад хамрагдаж байгаа судлаачдын талаарх судалгааг сургууль, нэгж тус бүрээр гаргаж судлаачдын сургалтын хөтөлбөрт тулгамдаж буй асуудлыг эрэмбэлэн тодорхойлж, шийдвэрлэхийн тулд асуулга судалгааг 1 удаа, хэлэлцүүлэг уулзалтыг 2 удаа зохион байгуулан Их сургуулиудтай дараах асуудлуудыг харилцан тохиролцож шийдвэрлэв.

Их сургуулиудтай байгуулсан гэрээ санамж бичгийн хүрээнд МУИС, ШУТИС, ХААИС, МУБИС-д суралцаж байгаа докторантуудын мэдээллийг нэгтгэн хүргүүлж, тэднийг хамгаалах, хөнгөлөлт, урамшуулалд хамруулах ажлыг зохион байгуулан ажиллаж байна. МУИС-ийн докторантурт суралцаж буй судлаачдын эрдэм шинжилгээний ажлын 12 багц цаг болон хоёр талын лаборатори ашиглалтын төлбөрт тодорхой хөнгөлөлт үзүүлэхээр тохиролцсоны дагуу 2022 онд шаардлага хангасан 17 судлаачийн ЭША-ы 12 багц цагийн төлбөрт 50 хувийн хөнгөлөлт үзүүлэх асуудлыг шийдвэрлэв. Мөн ШУТИС-ийн докторантурт суралцаж байгаа 5 судлаачдад докторантын туршилт судалгааны ажлын 10 кредит цагийн хөнгөлөлтийг ШУТИС-ийн захирлын тушаалаар чөлөөлүүлээд байна.

ШУА-ийн Их сургууль (UMAS)-ийг байгуулах ажлын бэлтгэл ажлыг хангаж, Засгийн газрын тогтоолын үндэслэл танилцуулгыг бэлтгэн танилцуулж, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн 214 дугаар тогтоолоор Шинжлэх Ухааны Академийн Их сургууль байгуулагдаж, 6 дугаар сарын 6-ны өдөр сургуулийн нээлтийн арга хэмжээг зохион байгуулж 10 мэргэжлийн чиглэлээр хөтөлбөр боловсруулав.

1.8 ШИНЖЛЭХ УХААНЫ СУРТАЛЧИЛГАА, ТҮГЭЭН ДЭЛГЭРҮҮЛЭЛТИЙН ТАЛААР

“Эрдэмтдийн үг -2023” лекц

ШУА-аас санаачлан, БШУЯ-ны дэмжлэгтэйгээр 2016 оноос эхлэн “Эрдэмтдийн үг” цуврал лекцийг зохион байгуулж ирсэн бөгөөд нийт 70 эрдэмтэн, судлаачид судалгааныхаа үр дүн, ач холбогдол, гарц шийдлийн талаарх лекцийг олон нийтэд уншсан байна. 2021-2024 оны байдлаар академич 8, шинжлэх ухааны доктор 14, доктор 5, нийт 38 эрдэмтэн оролцов.



Шинжлэх ухаан, танин мэдэхүйн хялбаршуулсан цуврал

ШУА-аас хүүхэд, багачуудад шинжлэх ухааны мэдлэг олгох, цаашлаад шинжлэх ухаанч иргэн болгон төлөвшүүлэх зорилтын хүрээнд “Шинжлэх ухааны хялбаршуулсан цуврал” бүтээлийг гаргадаг уламжлалтай бөгөөд 2021-2024 онд нийт 52 цувралыг хэвлэн нийтэлж, ЕБС-ууд болон номын сангуудад тарааж, нийтийн хүртээл болгосон байна. Хялбаршуулсан цуврал номыг 2015 оноос эхлэн хэвлүүлснээс нийт 108 дугаар ном хэвлэгдэн олон нийтийн хүртээл болсон байна.



“Үндэсний номын баяр” (2022 он)

“Үндэсний номын баяр”-ын өдөр буюу 9 дүгээр сарын 16-ны өдөр ШУА-аас эрхлэн хэвлүүлсэн “Амьдралыг тэтгэгч тогтолцооны нэвтэрхий толь” 3 боть бүтээлийн нээлт болов.

Тус бүтээлийг 2013 онд НҮБ-ын ЮНЕСКО болон Англи улсын Иолсс хэвлэлийн компанийн зөвшөөрлөөр англи, орос хэлнээс орчуулан хэвлэх эрхийн дагуу монгол хэлнээ хөрвүүлэх ажил эхэлж, академичид, эрдэмтэн судлаачид, орчуулагчид, эмхэтгэгчид нийт 90 гаруй хүний бүрэлдэхүүнтэйгээр 2016 онд I боть, 2017 онд II боть, 2021 онд III ботийг орчуулж, редакторлаж дуусгасан байна.

“Амьдралыг тэтгэгч тогтолцооны нэвтэрхий толь” бүтээлийн нээлтийн үеэр тус номыг бүтээгч орчуулагч, редактор, эрдэмтэн судлаачдад болон номын сангуудад номын дээжийг хүртээлээ.



“Эрдэм номын чуулган” шинэ ном хандивлах, танилцуулах аян

Шинжлэх Ухааны Академиас “Дэлхийн ном, зохиогчийн эрхийн өдөр”-ийг тохиолдуулан Монгол Улсын Үндэсний Номын Сантай хамтран зохион байгуулдаг уламжлалт “Эрдэм Номын Чуулган” шинэ ном хандивлах, танилцуулах аянд 2021-2024 онд нийт 1160 ном бүтээл, эрдэм шинжилгээний сэтгүүл зэргийг хандивлаад байна.

2021 онд 220 ширхэг ном, 2022 онд 364 ширхэг ном, 2023 онд 293 ширхэг ном, 2024 онд 283 ширхэг ном хандивлаж, номын танилцуулгыг видео контент болгон цахимаар танилцуулах, тус аяны талаар подкаст хийх, номын үзэсгэлэнг МУҮНС-д нээх, нийгэм хүмүүнлэгийн салбарын хүрээлэнгийн номын худалдаа хийх зэрэг үйл ажиллагаа жил бүрийн дөрөвдүгээр сард тогтмол зохион байгуулсаар байна.



“Эрдэм номын чуулган”-2023

“ШУА-ийн мэдээ” сэтгүүл

Монголын эрдэм шинжилгээний сэтгүүлүүдийн нэгдсэн платформ (MongoliaJOL)-ийг дэмжих, “ШУА-ийн мэдээ” сэтгүүлийн үйл ажиллагааг хөгжүүлэх зорилгоор “Эрдэм шинжилгээний сэтгүүлүүдийн нэгдсэн платформ (MongoliaJOL)-ыг дэмжих зарим арга хэмжээний тухай” ШУА-ийн Ерөнхийлөгчийн 2024 оны А/109 дугаар тушаал гаргаж, холбогдох зарим ажлыг зохион байгуулан ажиллаж байна. MongoliaJOL-ыг дэмжин хөгжүүлснээр дотоодын эрдэм шинжилгээний 2 сэтгүүл олон улсын нэр хүндтэй мэдээллийн сан Скопуст бүртгэгдэж, хэвлэн нийтэлсэн бүтээлүүдээс авагдсан эшлэлийн тоо нэмэгдсээр байна. ШУА-ийн харьяа хүрээлэнгүүдээс 2024 эхний хагас жилийн байдлаар Скопуст бүртгэлтэй мэргэжлийн эрдэм шинжилгээний сэтгүүлүүдэд 130 гаруй бүтээл хэвлэн нийтлүүлсэн байна.

“ШУА-ийн мэдээ”- “Proceedings of the Mongolian Academy of Sciences” (PMAS) сэтгүүлийг тогтмол эрхлэн гаргаж, дэлхийн нээлттэй мэдээллийн сангуудад индексжүүлж, үндэсний болон олон улсын хэмжээнд эрдэмтэн судлаачдын хүртээл болгосноор хэвлэгдсэн өгүүллүүдийн татагдсан тоо жилээс жилд нэмэгдэж, 2024 оны эхний хагас жилийн байдлаар 29,879 удаа татагдаж олны хүртээл болжээ. Түүнчлэн “Шинжлэх ухаан амьдрал” шинжлэх ухаан, танин мэдэхүйн сэтгүүлийг улирал бүр тогтмол эрхлэн гаргаж, эрдэмтэн судлаачдын хүртээл болгов.


“Шинжлэх ухаан, амьдрал” сэтгүүл

“Шинжлэх ухаан, амьдрал” сэтгүүлийн 2021-2024 оны дугаарууд тогтмол хэвлэгдэн нийтийн хүртээл болсоор байна. Сэтгүүлд эрдэм шинжилгээний өгүүлэл, түүнчлэн шинжлэх ухаан, танин мэдэхүйн нийтлэл, нэрт эрдэмтдийн тухай тэмдэглэл, шинэ ном, шинжлэх ухааны салбарын эргэн тойронд болж буй үйл явдлын товчооныг нийтлэн хэвлэж, холбогдох байгууллага, номын сангуудад түгээсээр байна.

“Нэг эрдэмтэн – нэг лекц” хөтөлбөр

Шинжлэх Ухааны Академиас Нийслэлийн боловсролын газартай хамтран “Нэг эрдэмтэн нэг лекц” хөтөлбөрийг хэрэгжүүлж ирсэн бөгөөд 2021 онд ШУА-ийн харьяа хүрээлэнгүүдийн судлаачид “Монгол нум”-ны үүсэл хөгжил”, “Ай савын ургамал, тэдгээрийн ач холбогдол, ашиглах боломж”, “Монгол орны ойжуулалт, ойн нөхөн сэргээлтийн өнөөгийн байдал цаашдын хандлага”, “Тоглоомын онол, түүний нийгэм-эдийн засгийн хэрэглээ”, “Исэлдэн - ангижрахын гайхамшиг”, “Микроэлементүүд. Хүний бие организмд гүйцэтгэх үүрэг, хэрэгцээ, дутал, нөхөх арга замууд” зэрэг сэдвээр лекц уншиж, ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад эрдэм түгээсэн байна.

Палеонтологийн хүрээлэнгийн эрдэмтэдтэй хамтран "Монгол орноос олдсон махан идэшт үлэг гүрвэлүүд" лекцийг Эрдмийн гүүр элит сургуульд зохион байгуулав.



“Хөгжилд хөтөлсөн бүтээлүүд” радиогийн нэвтрүүлэг (2021 он)

Монгол Улсад шинжлэх ухааны байгууллага үүсэж, хөгжсөний 100 жил, ШУА байгуулагдсаны 60 жилийн ойг тэмдэглэх хүрээнд ШУА-ийн харьяа хүрээлэнгүүдийн эрдэмтэн судлаачдын онцлох бүтээл, үр дүнг танилцуулахаар МҮОНР-ийн “Хөгжилд хөтөлсөн бүтээлүүд” нэвтрүүлэг долоо хоног бүрийн пүрэв, бямба гаргуудад цацагдаж, “Судар бичгийн хүрээлэнгийн үүсэл хөгжил”, “Шинжлэх ухааны салбарын түүхэн хөгжил”, “Монголчуудын бичиг үсэг, ном хэвлэлийн түүх”, “Цөлжилт”, “Хөрс судлал”, “Хөрсний эвдрэл”, “Цэвдэг судлал”, “Пазырыкийн үеийн булшны олдворууд”, Сарьдагийн хийдийн судалгаа”, “Монгол малын гений сан”, “Газрын тосны уламжлалт бус эх үүсгүүрийн тухай”, “Археологийн хүрээлэнгийн эрдэмтэн, судлаачдын нээлт, бүтээлүүд”, “Геологийн хүрээлэнгийн эрдэмтэн, судлаачдын нээлт, бүтээлүүд”, “Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн эрдэмтэн, судлаачдын нээлт, бүтээлүүд”, “Хими, химийн технологийн хүрээлэнгийн эрдэмтэн, судлаачдын нээлт, бүтээлүүд” гэх мэт 30 дугаарыг олон нийтэд хүргэсэн байна.

“Шинжлэх ухаан амьдралд” нэвтрүүлэг (2021 он)

ШУА-ийн түүхт 60 жилийн ойг тохиолдуулан Шинжлэх ухааныг сурталчлах түгээн дэлгэрүүлэх зорилгоор Монгол HD телевизтэй хамтран “Шинжлэх ухаан амьдралд” буланг шинээр нээж, нийт 14 дугаарыг эрхлэн гаргаж хүрээлэнгүүдийн үйл ажиллагаа, эрдэмтдийн судалгааг сурталчлав.

“Судлагдахуун” нэвтрүүлэг (2022)

Шинжлэх Ухааны Академи UBS телевизтэй хамтран шинжлэх ухаан, танин мэдэхүйн “Судлагдахуун” нэвтрүүлгийг хийж, ШУА болон харьяа хүрээлэнгүүдийн үйл ажиллагаа, эрдэмтэн судлаачдынхаа судалгаа шинжилгээний нээлт, үр дүн, гарц шийдэл, онцлох бүтээл ном, шинжлэх ухаан, танин мэдэхүйн ач холбогдолтой мэдээ мэдээллийг түгээн, ШУА-ийн Ерөнхийлөгч Д.Рэгдэлийн оролцсон нэвтрүүлэг, ШУА-ийн дэд ерөнхийлөгч Г.Чулуунбаатар, Палеонтологийн хүрээлэнгийн захирал Х.Цогтбаатар, Хими, химийн технологийн хүрээлэнгийн


захирал Л.Жаргалсайхан, Биологийн хүрээлэнгийн захирал Д.Гантулга, Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн захирал Ц.Цэрэндорж, Ботаникийн цэцэрлэгт хүрээлэнгийн захирал И.Түвшинтогтох, Технологийн инкубатор төвийн захирал Ч.Батсүх, Философийн хүрээлэнгийн захирал Б.Пүрэвсүрэн, ШУА-ийн удирдах ажилтны зөвлөгөөний тухай, “Археологи - Эртний соёлын ул мөрийг судлахуй” - доктор Г.Галдан, “Газарзүйн гайхамшиг” – Газарзүй, геоэкологийн хүрээлэнгийн эрдэмтэд, “Нарны эрчим хүч” – доктор Г.Пүрэвдорж, “Хэл ба сэтгэхүй” - доктор Н.Мөнхцэцэг, “Мөөгний гайхамшигт ертөнц” – ЭША Г.Бүрэнбаатар, “Монгол орны зэсийн ордын тархалт” доктор Н.Тунгалаг, “Монголчуудын нохой” – цуврал ЭША Г.Батболд, “Монголын эртний улсууд” – доктор Н.Ганбат, “Монгол орны халуун рашаан” доктор Д.Оюунцэцэг, “Хачгаар халдварлагддаг өвчнөөс сэргийлэх нь” – доктор Б.Уянга, “Монгол орны сонирхолтой цэцэгт ургамал” – доктор Х.Солонго, доктор М.Алтанбагана зэрэг эрдэмтэд оролцов.



1.9 САНХҮҮЖИЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТАЛААР

Олон жил хүлээгдэж байсан Шинжлэх ухааны хүрээлэнгүүдийн нэгдсэн цогцолборын хөрөнгө оруулалтыг 2020 оны улсын төсөвт тусгуулж, олон улсын стандартад нийцсэн нээлттэй, салбар дундын төрөлжсөн лаборатори, технологи дамжуулах төв бүхий “Шинжлэх ухааны хүрээлэнгүүдийн нэгдсэн цогцолбор”-ын бүтээн байгуулалтын ажил төлөвлөгөөний дагуу хэрэгжиж, лабораторийн зориулалт бүхий 3 гол объектыг энэ онд багтаан ашиглалтад оруулахаар төлөвлөн ажиллаж байгаа та бүхэнд дуулгахад таатай байна. Уг цогцолбор бүхэлдээ ашиглалтад ороход ажлын даалгавар, төлөвлөгөөний дагуу төрийн өмчийн эрдэм шинжилгээний болон бусад байгууллагын 3000 орчим хүн шилжин очиж ажиллах боломжтой болох юм.

ШУА-ийн Тэргүүлэгчдийн газар болон харьяа хүрээлэнгүүд 2024 онд онд улсын төсвөөс 39.1 тэрбум төгрөгийн санхүүжилт авч, 9 дугаар сарын 31-ний байдлаар 12.9 тэрбум төгрөгийн нэмэлт орлоготой ажиллаж байна. 2023 онд төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд 18.3 тэрбум төгрөгийн нэмэлт орлого олж ажиллалаа. Тус орлогыг 2020 онтой харьцуулахад улсын орлого 2.7 дахин, төвөөс авсан санхүүжилт 65 хувиар тус тус өссөн байна. Үүнийг графикаар харуулбал:



ШУА-ийн харьяа хүрээлэнгүүд гадаадын болон дотоодын байгууллагуудтай хамтарсан төсөл хэрэгжүүлж 2021-2024 онд олсон төсвийн бус орлогоор эрдэм шинжилгээний ажилтны

цалин хөлсийг нэмэгдүүлэх, ажиллах орчныг сайжруулах, хамтын төслийн үр дүнг ашиглах, судалгааны ажлыг үйлдвэр, аж ахуйн нэгж дээр нэвтрүүлэх зэрэг олон ажлууд хийгджээ.

Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 409 тоот тогтоолоор “Төрийн өмчит эрдэм шинжилгээний хүрээлэн, төвийн судалгааны үндсэн чиглэлийг тодорхойлох, санхүүжүүлэх журмыг баталсан. Үүний хүрээнд “Жагсаалт батлах тухай” БШУ-ны сайдын 2023 оны А/51 дугаар тушаалын дагуу Боловсрол шинжлэх ухааны сайдын 2023 оны 5 дугаар сарын 19-ны өдрийн Судалгааны үндсэн чиглэлийг санхүүжүүлэх зардал батлах тухай А/229 тоот тушаалаар 2023 онд ШУА-ийн харьяа 16 хүрээлэнд нийт 593.4 сая төгрөгийн санхүүжилт олгогдсон байна.

Мөн эрдэм шинжилгээний хүрээлэнгүүд үйл ажиллагааныхаа үндсэн чиглэлээр төрийн болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд оролцох боломжийг нээсэн нээж, “Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 3 дугаар зүйлийн 3.15-д “Засгийн газар, төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд үйл ажиллагааны тодорхой чиглэлээр шинжлэх ухааны суурь, хавсарга, технологи хөгжүүлэлтийн туршилт судалгаа болон инновацын судалгааны ажил, үйлчилгээ худалдан авах, захиалгын дагуу тухайн чиглэлийн төрийн өмчийн эрдэм шинжилгээний байгууллагаар гүйцэтгүүлэх харилцааг энэ хуулиар зохицуулахгүй” гэсэн нэмэлт өөрчлөлт оруулав. Энэ заалт 2024 онд хүчингүй болсон боловч 2024 онд ШУТТХ-ийн шинэчилсэн найруулгаар тус хуулийн 31.5-д “Засгийн газар, төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд нь энэ хуулийн 3.1.11-т заасан судалгааны үндсэн чиглэлээр шинжлэх ухаан, технологийн төсөл, суурь судалгаа, хэрэглээний судалгаа, технологийн туршилт зүгшрүүлэлтийн ажлыг төрийн өмчийн эрдэм шинжилгээний байгууллагаар гүйцэтгүүлэх харилцаанд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль хамаарахгүй” гэсэн заалт батлуулсан болно. Дээрх 2 заалтын хүрээнд ШУА-ийн харьяа хүрээлэнгүүд судалгааны ажлууд гүйцэтгэж байна.

Эрдэм шинжилгээний байгууллагын санхүүжилтийг олон эх үүсвэртэй болгон нэмэгдүүлэх, үр дүнд суурилсан санхүүжилтийг бий болгох чиглэлээр санаачилгатай ажилласны дүнд хүрээлэнгүүдийн санхүүжилт болон өөрийн үйл ажиллагааны орлогыг нэмэгдүүлж чадсан ба батлагдсан төсвийн хүрээнд Салбарын бага чуулгануудад тодорхой хэмжээний үйл ажиллагааны санхүүжилт шийдвэрлэх боломжийг бүрдүүллээ. Тайлант хугацаанд салбарын бага чуулган болон харьяа бүтцийн төрөлжсөн академиудын үйл ажиллагаанд тодорхой хэмжээний санхүүжилт олгож ажиллаа. Цаашид бага чуулгануудын жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд үндэслэн санхүүжилт олгох асуудлыг тогтмолжуулахаар төлөвлөн ажиллаж байна.

Бид 2021-2024 онд дээрх санхүүжилт, хөрөнгө оруулалт болон өөрийн орлогын хүрээнд хийсэн зарим үр дүнг дурдвал:

1. Эрдэм шинжилгээний байгууллагын санхүүжилтийг олон эх үүсвэртэй болгон нэмэгдүүлэх, үр дүнд суурилсан санхүүжилтийг бий болгох чиглэлээр санаачилгатай ажилласны дүнд хүрээлэнгүүдийн санхүүжилт болон өөрийн үйл ажиллагааны орлогыг нэгдүүллээ.
2. Лабораторийн багаж, тоног төхөөрөмжийн хүчин чадлыг нэмэгдүүлэх болон багаж, төхөөрөмж худалдан авах, хээрийн судалгааны ажил, хамтарсан экспедицүүдийн судалгааг дэмжихэд түлхүү анхаарч ажиллаа.
3. Боловсрол, Шинжлэх Ухааны Яамны дэмжлэгтэйгээр ШУА-ийн харьяа хүрээлэнгүүдийн компьютер, принтерийн хангамжийг асуудлыг шийдвэрлэлээ.
4. Төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж буй Шинжлэх ухааны хүрээлэнгүүдийн нэгдсэн цогцолборт 2020-2026 онд 154.5 тэрбум төгрөгийн санхүүжилт батлагдсан ба одоогоор 80 орчим тэрбум төгрөгийн санхүүжилт олгогдсон бөгөөд ажлын явц хэвийн байна.
5. ШУА-ийн харьяа хүрээлэнгүүд **нийт санхүүжилтийнхээ 30-аас доошгүй хувьтай тэнцэх менежментийн орлого тогтвортой олох** зорилт дэвшүүлэн ажилласан ба зорилтоо амжилттай хэрэгжүүллээ.

ХОЁР. ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, ИННОВАЦ, ТЕХНОЛОГИ

2.1 ШУА-ИЙН 2021-2024 ОНЫ БҮТЭЭЛИЙН ТОВЧОО


ШУА-ийн харьяа хүрээлэнгүүдэд 2024 оны байдлаар суурь судалгааны төсөл 41, шинжлэх ухаан, технологийн төсөл 6, улсын захиалгат төсөл 7, гадаадтай хамтарсан төсөл 52, грант төсөл 28, нийт 134 төсөл хэрэгжиж байгаагаас энэ онд 91 төсөл дуусаж байна.

Манай эрдэмтэд сүүлийн 4 жилд ном, нэг сэдэвт болон хамтын бүтээл 681, өгүүлэл 2927 (гадаадад 1332), илтгэл 4033 (гадаадад 1252)-ыг хэлэлцүүлж, нийт 7641 бүтээлийг олны хүртээл болгожээ.

Түүнчлэн патент 24, технологийн загвар 34, стандарт 44, ТЭЗҮ 12, аргачлал, гарын авлага 79, зөвлөмж 113, ашигтай загвар 7, зураг, каталог 451, шинжлэх ухааны хялбаршуулсан товхимол 103, нийтлэл өгүүлэл 473, лекц 678, авран хамгаалах судалгааны тайлан 455, лавлагааны материал 47, хээрийн судалгааны тайлан 243, социологийн тайлан 19-ийг тус тус гаргасан байна.

2023 онд ШУА-ийн харьяа хүрээлэнгүүдээс Scopus мэдээллийн санд бүртгэлтэй олон улсын сэтгүүлүүдэд 361, WoS мэдээллийн санд бүртгэлтэй олон улсын сэтгүүлүүдэд 231 бүтээл нийтлүүлж, эдгээр нь Scopus мэдээллийн санд 59,993 удаа эшлэгдээд, h-index=99 байна.

“Төрийн өмчит эрдэм шинжилгээний хүрээлэн, төвийн судалгааны үндсэн чиглэлийг тодорхойлох, санхүүжүүлэх журам”-ыг батлуулах үйл явцтай холбоотойгоор, мөн 2019-2021 онуудад үргэлжилсэн Ковид-19 цар тахлын дэлхийг хамарсан нөхцөл байдалтай уялдан судалгаа хөгжүүлэлт, түүний үр дүнг илтгэх хэвлэн нийтлэх үзүүлэлт тодорхой хэмжээнд буурсан үр дүн энэ онд харагдаж байна. Гэхдээ нөхцөл байдал эргэн сэргэснээр манай судлаачид гадаад хамтын ажиллагаагаа өргөжүүлж, олон арван хамтарсан төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхээр төслийн саналуудыг зохих байгууллагуудад хүргүүлээд байгаа нь ирэх жилүүдэд үр дүнгээ өгөх нь дамжиггүй.





Монголын эрдэмтдийн WoS, Scopus, Dimensions мэдээллийн сангуудад бүртгэлтэй эрдэм шинжилгээний сэтгүүлүүдэд хэвлүүлсэн бүтээлийн тоо /Сүүлийн 20 жилээр/

1967 онд Монгол Улсаас анхны эрдэм шинжилгээний бүтээл нь Web of Science мэдээллийн санд бүртгэлтэй эрдэм шинжилгээний сэтгүүлд хэвлэгдэж байсан бол 2007 онд 188, 2023 онд 813 болж нийт хэвлэгдсэн бүтээл сүүлийн 15 жилд 4.3 дахин өссөн үзүүлэлттэй байна. 2023 оны байдлаар манай улсаас хэвлэгдсэн нийт бүтээлийн тоо 449 байгаа бөгөөд байгууллагаар нь гаргавал ШУА 231, МУИС 138, АШУҮИС 147, ШУТИС 58, ХААИС 39, МУБИС 31 бүтээл тус тус хэвлүүлсэн байна.


Дээрх байгууллагуудын хэвлүүлсэн (2009 оноос 2024 он хүртэл) бүтээлийн олонх нь геологи, байгаль орчин, физик болон салбар дундын шинжлэх ухааны чиглэлээр гарч байна. Эдгээр нийт бүтээлээс дэлхийн шинжлэх ухаанд оруулсан үр нөлөөг 2023 оны байдлаар тооцож үзвэл нэг бүтээлээс дунджаар 13.67 эшлэл, h-index 93, нийтдээ 60840 эшлэл авсан байна.

1957 онд Монгол Улсаас анхны эрдэм шинжилгээний бүтээл нь Scopus мэдээллийн санд бүртгэлтэй сэтгүүлд хэвлэгдэж байсан бөгөөд 2024 оны 9 дүгээр сарын байдлаар манай улсаас хэвлэгдсэн нийт бүтээлийн тоо 10201-д хүрсэн байна.


Скопуст бүртгэлтэй мэргэжлийн сэтгүүлүүдэд хэвлүүлж буй бүтээлийнхээ тоогоор Монгол Улс Азидаа 21 дугаарт эрэмбэлэгдэж байгаа бөгөөд 2024 оны 9 дүгээр сарын байдлаар манай эрдэмтэд **10201** бүтээл гадаадад хэвлүүлсэн ба (h-index=146), нийт **172853** удаа эшлэл аваад байна.



ШУА-ийн эрдэмтдийн WoS мэдээллийн санд бүртгэлтэй
эрдэм шинжилгээний сэтгүүлүүдэд хэвлүүлсэн бүтээлийн тоо



ШУА-ийн эрдэмтдийн хэвлүүлсэн бүтээлийн эшлэгдсэн байдал



ШУА-ийн эрдэмтдийн 2021-2024 онд хэвлүүлсэн бүтээлийн тоо

2.2 ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ АЖЛЫН ОНЦЛОХ ҮР ДҮНГЭЭС

Нано бүтэцтэй тогтмол соронзон материал гарган авлаа.

Физик, технологийн хүрээлэнгийн Функционал материалын судалгааны багийнхан АНУ-ын Засгийн газрын 580 мянган ам.долларын санхүүжилтээр хэрэгжих “Энергийн ялгарал ихтэй тогтмол соронзонгийн нано материалын шинж чанарын судалгаа” төслийг АНУ-ын Оак-Риджийн судалгааны лаборатори, БНСУ-ын Инчоно Их сургууль, МУИС-тай хамтран хэрэгжүүлж эхлэв. Манай физикчид анх удаа эх орондоо лабораторийн нөхцөлд соронзон шинж чанар өндөртэй, газрын ховор элемент агуулаагүй, Fe_2P шинэ төрлийн квант материал гэж нэрлэгдэх тогтмол соронзонг гарган авлаа.

Батарейг сэргээн дахин ашиглах боломжийг бий болголоо.

Хосолсон хөдөлгүүртэй автомашины никель-металл-гидридийн (NiMH) хаягдал батарейн нурсан модулиудыг сэргээн, багтаамжийг нь нэмэгдүүлэн 12 ширхэг модулиар 24В-ын батарей угсарсан. Сэргээсэн модулиудын багтаамж нь 5-20%-аар нэмэгдэв. Угсарсан батарейг нарны зайн системтэй холбон бага чадлын цахилгаан үүсгүүрт ашиглах боломжтойг тогтоосон. Сэргээх боломжгүй хаягдал батарейн катодоос никель болон никель суурьтай 5 төрлийн нэгдлийг өндөр цэвэршилтэй ялган авч, цаашид катализатор болгон ашиглах боломжтойг туршилтаар тогтоов.

Их энергитэй адрон-цөмийн харилцан үйлчлэлийг судлав.

4.2 болон 10 ГэВ/с импульстэй протон нүүрстөрөгчийн цөмтэй харилцан үйлчлэх үед үүссэн хоёрдогч кумулятив протонуудын энерги нь тодорхойгүйн зарчмыг ашиглан гарган авсан томъёогоор мөн тодорхойлогдож байгаа болохыг харуулсан. Энэ нь адрон-цөмийн харилцан үйлчлэлээр үүссэн хоёрдогч кумулятив протонууд дамжуулалтын импульс ихтэй үед хөндөх онолын механизмаар үүсдэг болохыг харуулж байна.

Хүний царай таних хиймэл оюунд суурилсан технологи боловсруулав.

Математик, тоон технологийн хүрээлэн: Монгол хүний царай таних технологийг эх орондоо хөгжүүлэн хиймэл оюунд суурилсан хиймэл оюуны технологийн судалгааны хүрээнд царайг илрүүлэх, царай таних загваруудыг *tensorflow graph optimization* арга ашиглан илүү хурдан ажиллагаатай болгосон бөгөөд царай таних загварыг дахин сургаж, шинэ загвар гарган авч программыг туршиж, зүгшрүүлжээ. Царай таних программ вебд суурилсан интерфейстэй холбогдон бодит хугацаанд камераас таних, бичлэгээс өгөгдсөн хүнийг олох, бичлэгт байгаа бүх ялгаатай хүний олох зэрэг функцүүдийг алдаагүй гүйцэтгэн ажиллаж байна. Javascript программчлалын хэл дээр React ашиглаж веб интерфейс үүсгэн өөрсдийн боловсруулсан царай таних загварыг холбож өгөгдсөн бичлэгээс ялгаатай хүмүүсийг олох даалгаврыг туршихад нийт 7.7 минутын бичлэгийг 166 секундэд боловсруулж, 127 ялгаатай буюу өөр, өөр хүмүүсийг танин ялгаж, өгөгдсөн хүнийг хайж олох даалгаварт 5.41 минутын бичлэгийг 113 секундэд боловсруулсан бөгөөд өгөгдсөн хүний царайг 48 удаа олж таньсан байна.

Төсөв алдагдалгүй байх математик загварыг боловсруулав.

Хучилтын бодлогын глобал оптимизацийн арга, алгоритм, программ хангамж ба хэрэглээ судалгааны хүрээнд улсын төсвийн орлого, зарлагын бүтцийг оновчлохын тулд төсвийн орлого, зарлагын тоон судалгааг сүүлийн 10 жилээр хийж, төсөв алдагдалгүй байх математик загварыг боловсруулав. Мөн 200 жилийн түүхтэй Малфатийн бодлогыг Малфатийн хөдөлгөөнт бодлого болгон өргөтгөн томъёолсон бол тэгш өнцөгтийг 6 ижил дугуйгаар хучих эртний Японы Сангаку бодлогыг хучилтын бодлого хэлбэрээр томъёолж бодон тоон үр гаргав.

Математик, тоон технологийн хүрээлэн нь “Оновчлол, симуляци, оновчтой удирдлага-2022” олон улсын эрдэм шинжилгээний долоо дахь, мөн “Тооцон бодох ба хэрэглээний математик-2023” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурлуудыг зохион байгуулсан бөгөөд хурлын шилэгдсэн судалгааны бүтээлүүд нь Springer хэвлэлийн тусгай сэтгүүл болон хэвлэгдсэн.

Газар хөдлөлтийн мэдээллийг шуурхай зарлан мэдээлэх боломжийг бүрдүүлэв.

Одон орон, геофизикчид: Хүчтэй газар хөдлөлтийн мэдээллийг шуурхай зарлан мэдээлэх системийг бүрдүүлэн ажиллуулж байна. Уг систем нь Монгол орны нутаг дэвсгэр болон хил

орчмын бүс нутагт магнитуд нь 4.5 болон түүнээс дээш хүчтэй газар хөдлөлт болсон үед тухайн газар хөдлөлтийн анхдагч мэдээллийг 1-2 минутын дотор ОБЕГ-т, хянасан мэдээллийг олон нийтэд 10 минутад, дэлгэрэнгүй мэдээллийг "eq.iag.mn" цахим хуудсаар 20 минутад багтаан олон нийтэд хүргэх боломжийг бүрдүүлэв.

Станцуудаас ирж байгаа QSC.D форматтай мэдээллийг ашиглан хүчтэй газар хөдлөлтийг амжиж анхааруулах системийн программ хангамжийг шинэчилж U-larm v1.0 хувилбарыг бэлэн болгов.

Улаанбаатар хот орчмын газар хөдлөлтийн идэвхжилтийн зургийг зохиов

Улаанбаатар хот орчмын нутаг дэвсгэрт 1964-2021 онуудад болсон газар хөдлөлтийн мэдээлэлд дахин боловсруулалт хийж, газар хөдлөлтийн төвийн тархалтыг нарийвчлан тодорхойлж, сүүлийн 20 орчим жилийн хугацаанд тус бүс нутагт болсон хүнд мэдрэгдэм хүчтэй 6 газар хөдлөлтийн мэдээллийг нэмж тусган, Улаанбаатар хот орчмын газар хөдлөлтийн идэвхтэй хагарал болон идэвхжилтийн судалгаагаар “Улаанбаатар хот орчмын газар хөдлөлтийн идэвхжилт” 1:500,000 масштабтай зургийг зохион гаргалаа.

Цэнхэрийн халуун рашаанд тулгуурлан геотермалыг ашиглах боломжийг судлав.

Цэнхэрийн халуун рашааны бүс нутгийн цахилгаан дамжуулах чадварын 3-D загварыг тодорхойлсон бөгөөд тус загвар нь Цэнхэр, Гялгар, Бор тал халуун рашаануудыг холбосон хүчтэй цахилгаан дамжуулах чадварын бүс байгааг харуулсан. Тухайн цахилгаан дамжуулах чадварын тогтцыг бусад геофизик, геологи, геохимийн өгөгдлүүдтэй нэгтгэн авч үзсэнээр, энэ нь орчны өндөрлөг хэсэгт хуримтлагдах хур тунадас хагарлын дагуу урсах гүний усны циклийг үзүүлж буйг тогтоон Цэнхэрийн халуун рашаанд тулгуурлан геотермал энергийн хэрэглээг цаашид бий болгох боломжтой гэж дүгнэсэн.

Байгаль, орчны хамгааллын өндөр үр ашигтай бүтээгдэхүүнүүдийг биотехнологийн аргаар гарган авлаа.

Биологийн хүрээлэн: Ойн зонхилох хөнөөлт зүйлийн нэг Сибирийн хүр эрвээхэй (*Dendrolimus sibiricus* Tschetv.)-н хүрэнцрийн эсрэг сонгомол үйлчилгээтэй *B. thuringiensis* бактерийн омог илрүүлэн ‘БИО-ДЕНДРО’ биобэлдмэл гарган авч **Монгол Улсад ургамал хамгааллын зориулалтаар ашиглаж болох био-бэлдмэлийн жагсаалтад бүртгүүлэн**, уг хөнөөлт зүйлийн эсрэг биологийн тэмцэлд ашиглаж байна.

Хот, суурин газрын хөрс, усны урт хугацааны бохирдлоос урьдчилан сэргийлэх зорилготой гэр хорооллын нүхэн жорлонгийн бохирдол бууруулах ажилд биологийн идэвхтэй бичил биетнийг ашиглан гарган авсан бүтээгдэхүүн **Био-Ариус** бэлдмэлийг туршин Хөвсгөл, Завхан аймгуудад ашиглаж эхлээд байна.

Ботаникийн цэцэрлэгт хүрээлэн: Монгол орны ургамлын ангилалзүйн судалгааны үр дүнгээр “Монголын ургамлын аймаг” цуврал бүтээлийн 24 дэвтэр, “Монгол орны хөвд” цувралын 3 дэвтэр, “Монгол орны мөөгний аймаг” цувралын 4 дэвтэр, “Монгол орны хаг” цувралын 2 дэвтэр, “Монгол орны замаг” цувралын 15 дэвтрийг тус тус хэвлүүлэхээр төлөвлөн ажиллаж байгаагаас одоогоор “Монголын ургамлын аймаг” бүтээлийн 13 дэвтрийг хэвлүүлээд байна. Үүний 6 нь сүүлийн 4 жилд хэвлэгдэж олны хүртээл болжээ.

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 21 аймаг, 330 сумын нутаг дэвсгэрийн газарзүй, геоморфологи, байгалийн бүс бүслүүрийн онцлогт тохируулан тарьж ургуулах боломжтой мод, сөөг ургамлын жагсаалтыг гаргаж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тамгын газар болон аймаг, сумын засаг даргын тамгын газруудад хүргүүлж хэрэглээнд нэвтрүүлэв.

Асгатын мөнгө-полиметаллын хүдрийг байгаль орчинд ээлтэй аргаар баяжуулах, боловсруулах цогц технологийн шийдлийг олжээ.

Химийн хүрээлэн: Асгатын ордын мөнгө-полиметаллын хүдрээс стандартын шаардлага хангасан баяжмал гарган авах зохистой горимыг тогтоож, техноген баяжмалыг байгаль орчинд ээлтэй аргаар боловсруулж, цахилгаан химийн аргаар 97.98% цэвэршилттэй катодын зэс гарган авах цогц технологийг боловсрууллаа.

“Сорилтын болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхад тавих ерөнхий шаардлага MNS/ISO/IEC 17025:2018”-ыг хангасан 9 лабораторийг итгэмжлүүлж, 46 төрлийн бүтээгдэхүүн материалд 212 үзүүлэлтийг батлагдсан арга аргачлалын дагуу тодорхойлох, сорилт, хэмжилт, шалгалт тохируулга, баталгаажуулалтыг чанарын өндөр түвшинд гүйцэтгэх боломж бүрдэв.

Их-Ургац био бордоо гарган авах технологи боловсруулав.

Технологийн инкубатор: Засгийн газрын органик хөдөө аж ахуй эрхлэлт, экологийн цэвэр бордооны үйлдвэрлэлийг дэмжих бодлоготой нийцүүлэн ургацын гарцыг нэмэгдүүлэх, болцыг түргэсгэх, уураг, цавуулаг зэрэг чанарын гол үзүүлэлтүүдийг нэмэгдүүлэх, хөрсний үржил шимийг сайжруулах үйлчилгээ бүхий импортыг орлохуйц, байгаль, цаг уурын онцлогт тохирсон, байгалийн гаралтай, экологийн цэвэр, ашигтай бичил биетний ‘Их-Ургац био бордоо’-г туршилт судалгааны үр дүнд гарган авлаа.

Хаягдал малын ясыг боловсруулан бүтээгдэхүүний түүхий эд гарган авах технологийн туршилт, зүгшрүүлэлтийн ажлыг гүйцэтгэж химийн болон мембран шүүлтийн аргаар коллагены гидролизатыг ялган авах технологийг боловсруулан загвар бүтээгдэхүүнийг нунтаг байдлаар гарган аваад байна.

Цаг уурын иж бүрэн автомат станц суурилуулав.

Газарзүй, гео-экологийн хүрээлэн: ОХУ-ын Сибирь, Монгол, БНХАУ-ын Төвөдийн өндөрлөгийн цэвдэгтэй бүс нутгийг дайруулан Евразийн цэвдгийн урт хугацааны мониторингийн сүлжээ бий болгох зорилгоор Хөвсгөл аймгийн Дархадын хотгор, Алаг-Эрдэнэ, Мөнгөтийн Бөөрөгт, Архангай аймгийн Чулуутын голын хөндий, Багануур дүүрэгт 5 минутын интервалтай цаг уурын үзүүлэлтүүдийг хэмжиж 5 ш цаг уурын иж бүрэн автомат станцууд суурилуулж, уур амьсгалын өөрчлөлт цэвдгийн гэсэлтэд хэрхэн нөлөөлж буйг тогтоох цэвдгийн мониторинг судалгааг хийж байна.

“Монгол Улсын үндэсний атлас” бүтээл хэвлүүлэв.

Монгол орны газар зүй, байгаль орчин, байгалийн нөөц, нөхцөл, хүн ам, нийгэм, түүх, соёл, эдийн засгийн холбогдолтой нийт 246 сэдэвчилсэн зураг бүхий олон талт мэдээллийг агуулсан шинжлэх ухааны лавлагаа, мэдээллийн эх сурвалж бүхий “Монгол Улсын үндэсний атлас” бүтээлийг 30 гаруй байгууллагын 140 гаруй судлаачдын оролцоотойгоор монгол, англи хадмал орчуулгатай хэвлэн, олон нийтийн хүртээл болгов.

Ашигт малтмалын зураг зүйн синтез бүтээл зохиолоо.


Геологийн хүрээлэн: УУХҮЯ-ны захиалгаар “Татах хүч” ХХК болон ШУА-ийн Геологийн хүрээлэн хамтран хэрэгжүүлж буй сэдэвчилсэн судалгааны төслийн хүрээнд чулуулгийн хил заагийг тодруулах, үнэмлэхүй нас тодорхойлох, геохимийн шинжилгээний үр дүнд тайлалт боловсруулалт хийх, петрографийн судалгаа болон хурдсыг төлөөлөх тулгуур зүсэлтүүдийг давтан зураглах шинэчлэн зурах ажлуудыг гүйцэтгэн Монгол орны мезо-кайнозойн хурдсын геологи, тектоник, ашигт малтмалын 1:500000-ны масштабын зурагзүйн синтез бүтээлүүдийг анхлан зохиов.

Зэс-алтны порфирын төрлийн Хүрэл-Үнэгтийн ордын хүдэржилт үүсгэгч интрузив магмын эх үүсвэр, шимт магма, геодинамик орчинг тодруулах зорилгоор чулуулаг ба эрдсийн геохимийн судалгааг хийсний зэрэгцээ уран хар тугалганы аргаар чулуулгийн үнэмлэхүй насыг тодорхойллоо. Мөн ордын хүдэржилтийн гарал үүсэл, үүссэн орчныг тогтоох зорилгоор хүдрийн эрдсүүд дээр хүхрийн изотоп, хүдрийн эрдсийн геохими болон кварцын судал дахь ормын шинэлэг арга, аргачлалаар судалгааг гүйцэтгэж, үр дүнг олон улсын геологийн тойм сэтгүүлд хэвлүүлээ.

Үлэг гүрвэл, палеобиологийн шинэ зүйлүүд нээв.

Палеонтологийн хүрээлэн: Төв Азиас олддог махан болон өвсөн идэшт үлэг гүрвэлийн *Natovenator polydontus*, *Jaculinykus yaruui*, неогены хөхтөн амьтдын туулай хэлбэртэн багийн 1 зүйлийг *Alloptox gudrunae* мөн Ази тивд дахь анхны *Keramidomys* (эртний жижиг мэрэгч) төрлийн хувьслын үе шатыг илтгэж буй *Keramidomys sibiricus nov. spec.*, шилмүүст модны үрийн судалгаагаар *Schizolepidopsis ediae* шинэ зүйл, эртний ургамлын судалгаагаар кордаитын төрлийн *Cordaitea duranteae*, *Cordaitea longissimus*, *Cordaitea gobiensis*, ойм хэлбэртэнд хамаарагдах *Permocallipteris yamanussica* зүйл, Хөвсгөлийн сав газрын Хөхтолгойн зүсэлтээс шинээр өт

маягийн хэлбэртний *Floraconformis egiinensis* gen. et sp. nov зүйлийг тус тус тодорхойлон шинжлэх ухаанд нэршүүлээ. байна.



а. *Jaculinykus yaruui* үлэг гүрвэлийн анхдагч материал, судлагдсан дээж,
б, в. сэргээн босгосон зураг, г. Шилмүүст мод *Schizolepidopsis ediae*-ийн боргоцой болон үр

Археологийн дурсгалыг шинээр илрүүлэн бүртгэн баримтжуулав.

Монгол Улсын дорнод бүс нутаг Хэрлэн голын урд хэсгийг хамарсан өргөн хүрээний хайгуул судалгааг явуулснаар Монголын эзэнт гүрний үед холбогдох урд өмнө мэдэгдээгүй байсан 1200 гаруй дурсгалыг шинээр илрүүлэн бүртгэн баримтжуулж, тэдгээрээс 3 газарт археологийн малтлага судалгаа хийснээр холбогдох он цагийг нягтлан баталгаажуулж чадсан нь энэ чиглэлийн судалгааг шат ахиулсан амжилт юм. Турк улсын Ван аймгийн Чалдран сумын Хан тосгонд буй Хүлэгү хааны байгуулсан Аладагийн ордон хотын туурийн археологийн малтлага судалгаанд оролцож, хас тэмдэгтэй дээврийн дусал ваар, арслан дүртэй нүүр ваар бүхий гоёмсог дээвэртэй, дэлдэж зассан шороон суурьтай барилгыг илрүүлэн, буддын шашны сүм, ордон болохыг тогтоов. Мөн судалгааны хүрээнд хотын дэвсгэр зургийг үйлдэж, хотын гадна 1.2 x 1 км хэмжээтэй шороон хэрэмтэй, хэрэм нь эртний зассан замтай холбогдож буйг баталгаажуулаад байна.

ОХУ-ын ШУА-ийн Эдийн соёлын түүхийн хүрээлэнгийн Эрдэм шинжилгээний архивд хадгалагдаж байгаа Монгол-Төвөдийн экспедицийн ховор нандин материалуудыг анх удаа судалгааны эргэлтэд оруулж, “Ноён уулын олдворын нийтлэгдээгүй цомог, архивын материалууд (1920-1930-аад он)” каталогийг хэвлүүлж, олны хүртээл болголоо.

Археологичид Архангай аймгийн Хашаат сумын Номгоны хөндийд археологийн малтлага судалгаа хийж, Түрэгийн Кутлук Элтэрис хааны тахилын онгон цогцолборыг нээн (олон төрлийн эд өлгийн зүйл, оройн хэсэгтээ хос чонын дүрслэлтэй, руни бичгээр үхэр жилийн есдүгээр сар, Тэнгэрийн хөвүүн, Түрэг, согд бичгээр Кутлук каган хэмээн бичсэн, хэд хэдэн брахми үсэг бүхий гэрэлт хөшөөний хэсэг) илрүүлсэн нь Түрэгийн хаант улсын түүхийг өгүүлэх бичиг үсгийн үнэт эх сурвалж, шинэ нээлт болсон юм. Мөн Монгол Улсын Дорнод бүс нутаг Хэрлэн голын урд хэсгийг хамарсан өргөн хүрээний хайгуул судалгаа явуулснаар Монголын эзэнт гүрний үед холбогдох урьд өмнө мэдэгдээгүй байсан 1200 гаруй дурсгалыг шинээр илрүүлэн бүртгэн баримтжуулж, тэдгээрээс 3 газарт археологийн малтлага судалгаа хийснээр холбогдох он цагийг нягтлан баталгаажуулж чадсан бөгөөд энэ чиглэлийн судалгааг нэг шат ахиулсан юм.

Олон улс судлаачид “Олон улс судлал”, “Mongolian Journal of International Affairs” сэтгүүлүүдийг цахимжуулан, мэргэжлийн хянан магадлагаатай олон улсын нэгдсэн DOI (Digital Object Identifier) дугаар бүхий сэтгүүл болгон хөгжүүлэхийн зэрэгцээ Орос, Хятад, Япон, Солонгос, Герман, Франц, Энэтхэг, Турк, Вьетнам, Лаос, Казахстан орон судлал, бүс нутаг, олон талт хамтын ажиллагаа судлалын чиглэлээр явагдсан судалгааны үр дүнг нэгтгэн тоймлож, өнөөгийн байдал, хөгжлийн цаашдын чиг хандлагын талаар тодорхой санал дэвшүүлсэн томоохон бүтээлийг эрхлэн хэвлүүлсэн байна.

“Монгол Улсын түүх (XX, XXI зуун)” таван боть бүтээл туурвилаа.

Түүх, угсаатны зүйн хүрээлэн санаачлан “Монгол Улсын түүх (XX, XXI зуун)” бүтээлийг МУИС, МУБИС, ХИС, ШУА-ийн Философийн хүрээлэн, Архивын ерөнхий газрын эрдэмтэн

судлаачидтай хамтран туурвисан нь Монголын ойрх үеийн түүхийн судалгааны чиглэлээр хийгдэж буй анхны томоохон бүтээл боллоо. Тус бүтээл сүүлийн 30 гаруй жилд хуримтлагдан буй болсон судалгаа, сурвалж хэрэглэгдэхүүний сууринд тулгуурлан, ХХ зууны Монголын түүхийг бодит байдлаар үзэл сурталжуулалгүй үнэлж цэгнэн, түүхийн “цагаан толбо”-уудыг арилгасан, суурь шинжтэй бүтээл болсноороо ихээхэн ач холбогдолтой юм.

“Талын язгууртан” сантай хамтран “Хошуу нутаг судлал” цуврал эрдэм шинжилгээний 11 хурлыг зохион байгуулсан нь орон нутгийн түүх судлалыг хөгжүүлэх, эрдэмтэн судлаачид, судалгааны байгууллагууд, аймаг, орон нутагтай хамтын ажиллагаагаа эрчимжүүлэх, түүхийн судалгааны үр дүнг олон нийтэд сурталчлах, соён гэгээрүүлэх, мэдлэгийг түгээн дэлгэрүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

“Дэлгэрэнгүй тайлбартай Монголын нууц товчоон” бүтээл туурвилаа.

Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн ивээл дор “Дэлгэрэнгүй тайлбартай Монголын нууц товчоон” тулгуур эх сурвалжийн түүхийн дэлгэрэнгүй тайлбарыг анх удаа хийлээ. Түүхэн үйл явдал, газар усны нэр, түүхэн хүмүүсийн намтар үйл ажиллагааг олон хэлний түүхэн сурвалжийн мэдээгээр нягталж хийснээрээ шинжлэх ухааны ач холбогдолтой, дэлхийд хамгийн олон тайлбар зүүлт бүхий “Монголын нууц товчоон” болов.

“Философийн шинэ нэвтэрхий толь” орчуулгын бүтээлийг нийтийн хүртээл болголоо.

Философийн хүрээлэн: түгээмэл хэрэглэгддэг ойлголт, ухагдахуун, категори, нэрт философичдын намтар, философийн урсгалын тухай 1200 гаруй өгүүллийг түүвэрлэн эмхэтгэж, “Философийн шинэ нэвтэрхий толь” орчуулгын бүтээлийг нийтийн хүртээл болголоо. Философийн хүрээлэнгийн сүүлийн 30 жилийн хугацаанд гаргасан судалгааны дүнгээр “Монголын нийгмийн хөгжлийн асуудлууд” эмхэтгэлийг гарган, бодлого боловсруулж шийдвэр гаргах түвшний төрийн байгууллага, УИХ-ын Тамгын газар, ЗГХЭГ зэрэг байгууллагад хүргүүлэв.

Философичдын туурвисан “Шинэ нөхцөл дэх шинжлэх ухаан, технологи, инновацын бодлого” хэмээх бүтээл нь Шинжлэх ухаан технологи, инновацын бодлогын өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийж, цаашид сайжруулах талаар санал дэвшүүлсэн ач холбогдол бүхий бүтээл болсон юм.

Нэр томьёо судлалын цахим хуудас нээлээ.

Хэл, утга зохиолын салбарын эрдэмтэн судлаачид эх хэлнийхээ үгийн сангаас 60 мянга гаруй толгой үг, 80 гаруй мянган холбоо үг бүхий “Монгол хэлний их тайлбар толь”-ийн гар утсанд зориулсан аппликейшныг шинэчлэн бүтээхийн зэрэгцээ Нэр томьёо судлалын цахим хуудсыг нээж нийт 10450 стандартчилсан нэр томьёоны сан, Орос-Монгол нэр томьёоны 3 боть толь бичиг, шинжлэх ухааны түлхүүр нэр томьёоны цахим толь болон нэр томьёо судлалын ном бүтээл, нэр томьёо судлалын чиглэлээр зохион байгуулсан үйл явдал, мэдээ мэдээлэл бүхий www.terminology.mn нэр томьёоны цахим сайтыг ажиллуулж байна. Мөн “Монголын утга зохиолын нэвтэрхий толь” 3 боть, “Монгол хэл судлал” 15 боть хамтын бүтээлийг нийтийн хүртээл болголоо.

Анагаах ухааны салбарын эрдэмтэд SARS-CoV-2 илрүүлэх нуклейн хүчилд суурилсан 3 аргачлалыг практикт туршин тогтворжуулж, “COVID-19 халдварын илрүүлэг хийхэд сорьцыг багцалж шинжлэх аргачилсан зөвлөмж” боловсруулан батлуулж, үндэсний лабораториудад нэвтрүүллээ. Манай Улсад илэрсэн SARS-CoV-2 вирусийн омгийг БНХАУ-д анх илэрсэн (hCoV-19/Wuhan/Hu-1/2019) омогтой харьцуулан судалж, Монголд илэрсэн SARS-CoV-2 вирусийн гений бүрэн дарааллыг тогтоож, Генбанкинд бүртгүүллээ.

Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэнгийн эрдэмтэд уламжлалт Лидэр-7 тангаас гарган авсан Монфлю уусдаг мөхлөг эмийг Монгол Улсын эмийн бүртгэлд бүртгүүлж, эрүүл мэндийн практикт нэвтрүүллээ. Монфлю эм нь томуу, томуу төст өвчний үед халуурах, бие зарайх, толгой, хоолой өвдөх үед эмчилгээний үр дүн өндөр байгааг тогтоожээ. Түүнчлэн ходоодны архаг үрэвсэлд Гастрофайр шахмал, нойр булчирхайн архаг үрэвсэлд Халифорте капсул, яс, үений үрэвсэлд Гарди наалтыг хэрэглэхэд ямар нэг гаж нөлөөгүй, эмчилгээний үр дүн өндөр байгааг тогтоож, эрүүл мэндийн практикт нэвтрүүлэв.

Анагаах ухааны хүрээлэнгийн эрдэмтэд ходоодны хорт хавдрыг эрт илрүүлэхэд хүний цусны ийлдэсний пепсиноген чухал нөлөөтэй болохыг тогтоож, ходоодны дурангийн шинжилгээ хийлгэхээс өмнө ийлдэсний пепсиногенээр оношилгооны шалгуур гаргаж, эрт илрүүлэх боломжтойг тогтоожээ. Түүнчлэн амны хөндий, залгиур хоолой зайлах жамц давсны уусмалын бактерийн эсрэг үйлдлийг судалж, жамц давсны уусмал ба хадаасан цэцгийн усан хандны нийлмэл найрлага бүхий бактерийн эсрэг уусмал “Домч” ам зайлах бүтээгдэхүүнийг гарган авч, практикт нэвтрүүлээ.

Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн судлаач, эрдэмтэд ДЭМБ-ын Коронавирусийн халдварын оношилгоо, эмчилгээний эмнэл зүйн удирдамжид хүний хэвийн иммуноглобулиныг хэрэглэх талаар тусгагдсантай холбоотой 10%-ийн 1.5 мл-ээр савласан иммуноглобулины 3 цуврал бүтээгдэхүүн гарган авч, 5000 тун бүтээгдэхүүнийг үйлдвэрлэв. Уургийн бэлдмэлүүд үйлдвэрлэх шинэ технологи нутагшуулах, эмчилгээний үр дүнг сайжруулах, импортыг орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжийг бүрдүүлсэн ач холбогдолтой юм.

Тархи, сэтгэл судлалын хүрээлэнгийн судлаачид нойронд амьсгал тасалдах хам шинжээс урьдчилан сэргийлэх, эмчлэх зорилгоор эрүү залгах зэмсгийг практикт нэвтрүүлж, Нойронд амьсгал тасалдах хам шинжтэй 30 хүнд эрүү залгах зэмсгээр ажиглалт хийхэд нойрны чанар сайжирч байгааг тогтоолоо.

Хөдөө аж ахуйн салбарын эрдэмтэд судалгааны ажлын үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, шинжлэх ухаан, үйлдвэрлэлийн холбоог бэхжүүлэхэд ахиц гаргаж, оюуны бүтээл болох оношлуур, цомгуудыг зах зээлд нийлүүлээ. ХААИС-ийн дэргэд малын эмнэлэг байгуулж, шүлхийн вакцин үйлдвэрлэх технологи боловсруулан баталгаажуулж, практикт нэвтрүүлэхээр Биокомбинатад үйлдвэрлэхээр шилжүүлэв. Газар тариалангийн салбарын эрдэмтдийн боловсруулсан ган, өвчин хортонд тэсвэртэй улаан буудайн Дархан сортын тариалалтын хэмжээ Монгол Улсын нийт тариалангийн талбайн 40%-д хүрсэн байна.

Мал эмнэлгийн хүрээлэнгийн эрдэмтэн судлаачид Цөмийн энергийн агентлагийн тусламжтайгаар нанопоре технологи (MinION)-йг малын эрүүл мэндийн судалгаанд нэвтрүүлж, халдварт өвчнийг үүсгэгч *Brusella abortus* бүтэн геномын дарааллыг амжилттай тогтоосон нь малын өвчний оношилгоо, вакцин хөгжүүлэлт, эмчилгээний шинэ арга боловсруулахад чухал ач холбогдолтой болжээ. Шүлхийгээс сэргийлэх вакцины технологийг боловсруулж, хоногт 100.0 мянган тун, сард 3.0 сая тун вакцин үйлдвэрлэх хүчин чадалтай цехийг ашиглалтад оруулан, уг бүтээлийг эдийн засгийн эргэлтэд оруулж, шүлхийн вакциныг үйлдвэрлэх болсноор импортыг орлох дотоодын вакцины нийлүүлэлтэд чухал ач холбогдолтой боллоо.

Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн судлаачид Молекул, биологи генетикийн лабораторийг шинээр байгуулж, сарлагийн геномын судалгаагаар дараах онцлох үр дүнг гаргажээ. Сарлагийн амьдын жин, зүсийг хариуцсан 12 SNP маркерийг илрүүлж, Монгол орны экологийн ялгаатай бүс нутагт малладаг популяц тус бүрийн сарлагийн геномын дараалал дахь өвөрмөц дан нуклеотидын задлан шинжилгээгээр илэрсэн генетик олон янз байдал, генетик зай, түүний ялгаа, генетик хольцын шинжилгээ зэргээс харахад сарлагийн популяцууд нь 4 фено болон 2 гено хэвшилд хуваагдаж байгааг тогтоожээ. Тэжээлийн таримлын үр болон малын үүлдэр, омгийн судалгаа хийж, баталгаажуулах талаар тодорхой үр дүнд хүрсэн. Тухайлбал, улсын сорт сорилтын зөвлөлөөр Царгасны Вега-87 сортыг ирээдүйтэй, Сибирийн Өлөнгийн (*Elymus sibiricum*) МК-00139 таримал хэлбэрийг нутгийн уугуул сортоор хэлэлцүүлж батлуулжээ. Түүнчлэн үхрийн “Дадал ухаа” үүлдрийн тодорхойлолтыг батлуулж, Цагаан-Овоогийн хар, Хөвчийн улаан, Тээлийн улаан омгийн ямааны биологи, ашиг шимийн үзүүлэлтийн судалгааг хийж, тодорхойлолтыг бичиж боловсруулав.

Ургамал газар тариалангийн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн судлаачид тариалангийн үйлдвэрлэлийн тулгамдсан асуудал болох үрийн шинэчлэлд онцгойлон анхаарч ажиллажээ. Бордооны үндэсний стандарт 2-ыг, мөн жимсний болон буудайн тарих үрийн чанарын стандарт 2-ыг, түүнчлэн хүнсний ногооны үрийн техникийн шаардлага 2-ыг тус тус боловсруулж батлуулав. Сонгино, байцаа, вандуй, улаан буудайн таримлын 8 сортыг судлан шалгаруулж, улсын сорт сорилтод сориулахаар шилжүүлж, Бөөрөнхий сонгинын “Tieasaku-1” сорт, буудайн “Дархан-212” сортыг ирээдүйтэй сортоор, буудайн Дархан-172 сортыг нутагшсан сортоор тус тус батлуулжээ. Шинэ таримал, сортыг тариалан эрхлэгчдэд түгээх, таримал ургамлын нутагшсан ба

ирээдүйтэй сортын эх үр гаргах, үрийн шинэчлэл хийх зорилгоор 2023 онд буудайн Дархан-144 сортын 350 тонн супер элит үр; Дархан-193, Дархан-160, Дархан-172 сортын 160 тонн элит үр; арвайн 60 тонн; хошуу будааны 56 тонн элит үр; төмсний нутагшсан сортын 115 тонн элит үр, хүнсний ногооны 5 таримлын 1 тонн элит үр; жимс жимсгэнэ, чимэглэлийн 9 төрлийн ургамлын 57.0 мянган суулгацыг тус тус үйлдвэрлэж, дараагийн шатны үр үржүүлэгчид болон тариаланчдыг хангажээ.

Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн судлаачид Төв, Дархан-Уул, Сэлэнгэ, Орхон, Говьсүмбэр, Өмнөговь, Дорноговь, Дундговь аймгийн тариалан эрхэлдэг бүх сумдын нутагт ажиллаж, Төвийн бүсийн Сэлэнгэ, Орхон аймгийн 18 сумын иргэн, аж ахуйн нэгжийн талбайн 108 цэгт, Төв, Дархан уул аймгийн 18 сум, Говийн бүсийн Өмнөговь, Дорноговь, Дундговь, Говьсүмбэр аймгуудын 24 сумын төмс, хүнсний ногоо, буудай, жимс, жимсгэнэ, хүлэмжийн тарималд тархсан хөнөөлт организмыг бүртгэж, дээж цуглуулан, тархалт, хөнөөлийн судалгааг хийж гүйцэтгэв. 4 аймгийн нийт 16 суманд бэлчээрийн хөнөөлт царцааны тархалт, олшролтыг тогтоолоо. Тариалангийн газрын хог ургамал, хортон шавьж, хөнөөлт мэрэгч, ургамлын өвчний болон хөнөөл учруулагч организмын зүйлийн бүрэлдэхүүн, тархалт, олшролт, хор хөнөөлийн түвшнийг тогтоох судалгааг Зүүн бүсийн 3 аймгийн тариалан эрхэлдэг 31 сум, 60 гаруй аж ахуйн нэгж, иргэдийн талбайд хийж, тэмцэх аргын зөвлөмж, гарын авлага боловсруулж нийтийн хүртээл болгов. Түүнчлэн 4 овгийн 4 зүйлийг лавр навчит улиас, тарваган хайлаас, ледбурын бургас, чацаргана чуйская сортын нийт 300 ширхэг тарьцыг нөхөн тариалжээ.

Техник, технологийн салбарын судлаачид Дэлхийн банкны санхүүжилтээр “Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн зарим хороонд үүсдэг халианы ус, М-Си-Эс Кока Кола ХХК-ийн үйлдвэрийн цэвэрлэсэн хаягдал усыг дахин цэвэрлэж, Амгалан дулааны станцад нэмэлт усаар ашиглах төслийн ТЭЗҮ-г боловсруулж ЭХЯ-ны шинжлэх ухаан технологийн зөвлөлөөр хэлэлцүүлсэн байна. Мөн ЭХЯ-ны захиалгаар 15 төрлийн шахмал түлшний, 3 төрлийн асаагчийн нийт 24 туршилтыг хийж гүйцэтгэн дүгнэлт гарган холбогдох байгууллагад хүргүүлсэн байна.

Байгаль орчинд халгүй технологийн боловсруулжээ. Тухайлбал, үхрийн ширний үсийг уусгалгүйгээр хадгалж авах, арьс ширийг хромгүйгээр идээлэх easy white tanning-биоорганик систем бүхий энгийн болон хосолмол технологийн шийдлийг туршин, үйлдвэрийн хаягдал ус болон боловсруулсан савхи, ширний шинж чанарын үзүүлэлтүүдийг тодорхойлон, үнэлж, байгаль орчинд халгүйгээр боловсруулах шинэчилсэн технологийн зөвлөмжийг боловсруулсан байна.

Уурхайн геотехникийн судалгааг хийж судалгааны үр дүнд чулуулгийн физик-механикийн шинж чанарын үзүүлэлт, хөрсний овоолгын сийрэгжсэн сул чулуулгийн геотехникийн шинж чанарын үзүүлэлт, томоохон ордын геотехникийн загварчлалыг тус тус боловсруулсан байна. Мөн алтны үндсэн болон цэс, жонш, төмрийн хүдэр, нүүрсний ордуудын хөрсний чулуулгийн геотехникийн үндсэн үзүүлэлтүүдийн нэгдсэн ангиллыг боловсруулжээ.

Баянхонгор аймгийн ойн тогтвортой менежментийн төлөвлөгөө /ОТМТ/ боловсруулан холбогдох байгууллагад хүлээлгэн өгсөн байна. Мөн Монгол орны Доройтсон Ойг Нөхөн Сэргээх, Ашиглах, Инновацын “ДОНСАТИ санаачилга”-ийг анхлан хэрэгжүүлэн эрдэм шинжилгээний анхдугаар хурал зохион байгуулав.

2.3 ИННОВАЦ, ТЕХНОЛОГИЙН ТАЛААР

Улсын захиалгат төсөл санаачлан хэрэгжүүлэх талаар

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050”, Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр (2020-2024)-ийн зорилтуудыг хэрэгжүүлэх чиглэлд үндэслэн Шинэ сэргэлтийн бодлогын Аж үйлдвэрийн сэргэлтийн хар төмөрлөгийн үйлдвэрлэл, түүний дагалдах туслах үйлдвэрлэлийг хөгжүүлэх зорилтын хүрээнд Хими, химийн технологийн хүрээлэнгийн дэргэд байгуулагдсан “Гарааны гранд стелла” ХХК-ийн хар төмөрлөгийн цутгуурын тэжээгүүр бүтээгдэхүүн үйлдвэрлэх технологийн процесс, үйлдвэрлэлийн хүчин чадлыг сайжруулснаар импортыг орлох бүтээгдэхүүний тоо хэмжээ нэмэгдэв.

Шинэ сэргэлтийн бодлогын Ногоон хөгжлийн сэргэлтийн зорилтын хүрээнд ШУА-ийн холбогдох хүрээлэнгүүдийн эрдэмтэн судлаачдыг зохион байгуулалтаар хангаж Тэрбум мод үндэсний хөдөлгөөнд оролцох сургагч багш бэлтгэх сургалт, сургалтад ашиглах гарын авлага, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд ашиглах зөвлөмжийг боловсруулан ЕТГ, БОЯ, Ойн газар болон аймаг, орон нутгийн удирдлагад хүргүүлж ажиллав.

Энтрепренер судлаач үндэсний хөтөлбөр

ШУА-ийн хэмжээнд 2018-2020 онд хэрэгжүүлсэн "Энтрепренер судлаач 21" төслийн үр дүнд тулгуурлан “Энтрепренер судлаач” үндэсний хөтөлбөрийг боловсруулан БШУЯ-ны дэмжлэгтэйгээр хэрэгжүүллээ.

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050”, НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилго 2030, Шинжлэх Ухааны Академийн Дунд хугацааны стратеги (2018-2025) төлөвлөгөөний хүрээнд “Энтрепренер судлаач” үндэсний хөтөлбөрийг СЭЗИС-тай хамтран хэрэгжүүлэв. Энтрепренер судлаач үндэсний хөтөлбөрийг 3 үе шаттайгаар хэрэгжүүлсний дүнд, төр болон хувийн хэвшил бизнесийн байгууллагуудаас нийт 150 энтрепренер судлаачид бэлтгэгдэн, тэдгээрээс шинээр 8 оюуны өмч мэдүүлэг гаргаж, судалгаанд суурилсан 18 бизнес төслийг хөгжүүлсэн байна.

Эрдэм хакатон

Үндэсний инновацын тогтолцооны гол оролцогчийн хувьд олон талт хамтын ажиллагааг хөгжүүлэхэд анхаарч ажиллав. Монголын инновацын 7 хоног арга хэмжээний хүрээнд “Эрдэм хакатон” тэмцээнийг уламжлал болгон жил бүр зохион байгуулж, оролцон үйл ажиллагааны цар хүрээ, оролцогч талуудын оролцоог нэмэгдүүлэхэд анхаарч ажиллав. Үр дүнд нь оролцогчдын төслийн санал, чанар сайжрахаас гадна бизнес, үйлдвэрийн байгууллагууд тус тэмцээнийг дэмжиж хамтран ажиллаж байна.

Сүүлийн жилүүдэд “Эрдэм хакатон” тэмцээний цар хүрээ нь өргөжиж Европын холбооны санхүүжилттэй “Бүгд залуусын төлөө, залуус бүгдийн төлөө” төсөл, СЭЗИС, Эрдэнэт Шинжлэх ухаан технологийн парк, Европ Дархан Инновац, энтрепренершип төв, Мэдээлэл технологийн үндэсний парк, Стартап Монгол ТББ зэрэг байгууллагууд хамтран зохион байгуулдаг боллоо.

Энэ оны 6 дахь удаагийн “Эрдэм хакатон-2024” тэмцээнийг анх удаа орон нутагт зохион амжилттай зохион байгууллаа. Энэ удаагийн тэмцээнд Улаанбаатар, Эрдэнэт хот, Булган аймгаас нийт 34 төсөл бүртгүүлснээс хоёрдугаар шатанд 20 төсөл тэнцсэн юм. Эцсийн шалгаруулалтад төслийнхөө үнэ цэн, эдийн засгийн эргэлт, үр өгөөж, загвар бүтээгдэхүүн, үйлчилгээгээ танилцуулж өрсөлдсөнөөр шилдэг 3 төсөл шалгарсан юм.

Шинжлэх Ухааны Академийн дэргэдэх хамтын оффис ба гарааны компани

Инновацын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4 дэх заалт, Засгийн газрын 2023 оны 39 дугаар тогтоолоор баталсан “Гарааны компани болон программ хангамжийн үйлдвэрлэл, хөгжүүлэлтийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжид дэмжлэг үзүүлэх журам”-ын дагуу Шинжлэх Ухааны Академийн дэргэдэх хамтын оффис нь БШУЯ-тай 2024 оны 05 дугаар сарын 08-ны өдөр ШУТБИХХЗГ-2024/142 тоот “Хамтран ажиллах гэрээ”-г байгуулж ШУА-ийн дэргэдэх Хамтын оффисын үйл ажиллагаа эхэллээ.

Оюуны өмч

2021-2024 онуудад ШУА-ийн харьяа хүрээлэнгүүдийн инновацын мэргэжилтнүүдийн ур чадварыг хөгжүүлэх, мэдлэг олгох, салбарын цаг үеийн мэдээ, мэдээллээр хангах ажлыг жил бүр уламжлал болгон зохион байгуулав. Мөн Монгол Улсын Оюуны өмчийн газар, TISC хөтөлбөрийн хамтын ажиллагааны хүрээнд Оюуны өмчийн сургалтыг уламжлал болгон зохион байгуулж хэвшүүлэв.

Монгол Улсын Оюуны өмчийн газар, Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчдийн холбоотой хамтран шинжлэх ухаан, технологийн салбарт мэргэшсэн хүний нөөцийг бэлтгэн, чадавхжуулах хөтөлбөр хэрэгжүүлсний үр дүнд ШУА-ийн ТГ 2, харьяа хүрээлэн 11 (ХХТХ-4, БХ-2, БотЦХ-1, ФТХ-1, МТТХ-1, ПХ-1, ГТХ-1), нийт 13 судлаач албан ёсоор оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч боллоо.

Оюуны өмчийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ШУА-ийн эзэмшилд байгаа хүчин төгөлдөр аж үйлдвэрийн оюуны өмчид үнэлгээ хийлгэх ажлыг 2023 оны 10 дугаар сард эхлүүлж, нийт 7 хүрээлэнгийн 47 аж үйлдвэрийн өмчид үнэлгээ хийлгэв. Эдгээрт: шинэ бүтээл 28, ашигтай загвар 8, барааны тэмдэг 11 байна. Үүнээс: Биологийн хүрээлэн 14, Хими, химийн технологийн хүрээлэн 12, Ботаникийн цэцэрлэгт хүрээлэн 4, Технологийн инкубатор 2, Газарзүй, геоэкологийн хүрээлэн 2, Одон орон, геофизикийн хүрээлэн 1, Физик технологийн хүрээлэн 1 шинэ бүтээл, ашигтай загвар болон 11 барааны тэмдэгт байна.

ГУРАВ. ДҮГНЭЛТ, ЗОРИЛТ

2021-2024 оны үйл ажиллагааг товч дүгнэвэл:

Шинжлэх ухаан, технологийн салбарын эрхзүйн орчин нөхцөлийг сайжруулах, дэд бүтцийг хөгжүүлэх, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050”, Засгийн газрын “Шинэ сэргэлтийн бодлого”-ын хүрээн дэх шинжлэх ухааны салбарын оролцоо, хувь нэмрийг нэмэгдүүлэх, ШУА-ийн Их, бага чуулганы шийдвэрийг хэрэгжүүлэх, харьяа хүрээлэнгийн судалгааны чиглэл, бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, төр, засагт зөвлөмж хүргэх, дотоод, гадаад харилцааг өргөтгөн үр өгөөжийг нь сайжруулах чиглэлээр бодит ахиц гарлаа.

Шинэ мэдлэг бүтээх, түүнийг хэрэглээнд нэвтрүүлэх, нийгмийг соён гэгээрүүлэх чиг үүргийнхээ дагуу хийж гүйцэтгэдэг уламжлалт ажил, арга барилаа улам сайжруулахын төлөө идэвх санаачилгатай ажиллалаа.

Өнгөрсөн 4 жилд Монгол Улсын шинжлэх ухаан, технологийн салбарын бодлого, түүний хэрэгжилт ШУА-ийн үйл ажиллагааны байдлыг нэгтгэн дүгнэж үзвэл:

Шинжлэх ухааны ажилтны улсын хоёрдугаар их хурлыг зохион байгуулах, Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг УИХ-аар батлуулах ажилд идэвхтэй оролцсоноор салбарын эрх зүйн орчныг шинэчлэх чиглэлд бодит алхам хийгдлээ.

ШУТ-ийн тухай хуулийн шинэчилсэн найруулгаар төрөөс эрдэм шинжилгээний байгууллагын санхүүгийн эрх чөлөөг нэмэгдүүлэх, төрийн болон төрийн өмчийн оролцоотой байгууллагуудын судалгаа, хөгжүүлэлтийн ажлыг шууд гэрээгээр гүйцэтгэх эрх зүйн орчныг бий болгосон нь төр-шинжлэх ухаан-үйлдвэр, бизнесийн хамтын ажиллагааг дэмжих бас нэг чухал эхлэл болсон гэж үзэж байна.

Шинжлэх Ухааны Академийн Их сургууль (UMAS)-ийн төслийг 2022 оноос үе шаттайгаар хэрэгжүүлсний дүнд Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн 214 дүгээр тогтоолоор Шинжлэх Ухааны Академийн Их сургууль байгуулагдлаа.

Төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж буй Шинжлэх ухааны хүрээлэнгүүдийн нэгдсэн цогцолборт нийт 80 орчим тэрбум төгрөгийн санхүүжилт олгогдсон бөгөөд ажлын явц хэвийн байна.

ШУА-ийн гишүүний ээлжит сонгуулийг 2 удаа зохион байгуулж, 10 залуу эрдэмтнээр эгнээгээ өргөтгөлөө. Түүнчлэн Монгол Улсын ШУА-ийн гадаад гишүүнээр ОХУ-ын Ломоносовын нэрэмжит Москвагийн Улсын Их сургуулийн Газарзүйн факультетын ерөнхийлөгч, Оросын газарзүйн нийгэмлэгийн тэргүүн дэд ерөнхийлөгч, академич Николай Сергеевич Касимов, Япон улсын Осака олон улсын Их сургуулийн хүндэт профессор, доктор Койчи Мацуда нар сонгогдлоо.

Тайлант хугацаанд ном, нэг сэдэвт болон хамтын бүтээл 681, өгүүлэл 2927 (гадаадад 1332), илтгэл 4033 (гадаадад 1252), нийт 7641 бүтээл хэвлэн нийтлүүлсэн байна.

Скопуст бүртгэлтэй мэргэжлийн сэтгүүлүүдэд хэвлүүлж буй бүтээлийнхээ тоогоор Монгол Улс Азидаа 21 дугаарт эрэмбэлэгдэж байгаа бөгөөд 2024 оны 9 дүгээр сарын байдлаар манай эрдэмтэд 10201 бүтээл гадаадад хэвлүүлсэн ба (h-index=146) нийт 172853 удаа эшлэл аваад байна.

ШУА-ийн гадаад харилцаа, хамтын ажиллагаа өргөжиж, 13 улсын нийт 24 байгууллагатай 7 санамж бичиг, 3 гэрээ, 9 хэлэлцээр, 5 протокол байгуулж, 14 улсын бүрэн эрхт элчин сайд, зочид төлөөлөгчийг хүлээн авч уулзан 13 хамтын ажиллагааг шинээр эхлүүлж, олон улсын 8 байгууллагын гишүүн, удирдах зөвлөл болон Их чуулганд төлөөлөгчөөр сонгогдон ажиллах зэргээр гадаад хамтын ажиллагааны боломжийг өргөтгөлөө.

Энтерпренер судлаач үндэсний хөтөлбөрийг санаачлан 3 үе шаттайгаар хэрэгжүүлсний дүнд, төр болон хувийн хэвшил бизнесийн байгууллагуудаас нийт 150 энтерпренер судлаачид бэлтгэгдэн, тэдгээрээс шинээр 8 оюуны өмч мэдүүлэг гаргаж, судалгаанд суурилсан 18 бизнес төслийг хөгжүүлсэн байна.

Оюуны өмчийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ШУА-ийн эзэмшилд байгаа хүчин төгөлдөр аж үйлдвэрийн оюуны өмчид үнэлгээ хийлгэх ажлыг эхлүүлж, нийт 7 хүрээлэнгийн 47 аж үйлдвэрийн өмчид үнэлгээ хийлгэв.

Шинжлэх Ухааны Академийн дэргэдэх Хамтын оффисын үйл ажиллагаа эхлүүлж, харьяа хүрээлэнгүүдийн дэргэд инновацын төсөл хэрэгжүүлэх 5 гарааны компани, 1 инновацын төслийг бойжуулах ажлыг эхлүүлээд байна.

Цаашид:

Монгол Улс шинжлэх ухааны салбарыг хөгжүүлэх стратеги төлөвлөгөөг боловсруулах цаг ирснийг Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх Шинжлэх ухааны ажилтны II их хурлын үеэр бидэнд онцлон анхааруулсан. Энэ бол төрийн тэргүүний зүгээс бидэнд өгч байгаа үйл ажиллагааны гол чиглэл гэж ойлгон хүлээн авсан.

ШУА-ийн шинээр сонгогдох удирдлага ирэх 4 жилд дараах асуудлуудад анхаарлаа төвлөрүүлж ажиллах нь оновчтой гэж үзэж байна.

Нэгдүгээрт, Шинжлэх ухаан, технологийн салбарын хүний нөөцийн цогц бодлогыг хэрэгжүүлж, эрдэмтэн судлаачдын ажиллах орчин нөхцөл, цалин хангамж, нийгмийн тулгамдсан асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэх хэрэгтэй байна. Манай улсын шинжлэх ухааны салбарын мэргэшсэн хүний нөөц туйлын хангалтгүй, нэг сая хүнд ногдох эрдэм шинжилгээний ажилтны тоогоороо Азийн дунджаас 3 дахин бага хэвээр байна.

Энэ зорилтыг ханган хэрэгжүүлэхийн тулд УИХ, Засгийн газар илүү шийдэмгий зоримог бодлого, шийдвэрийг гаргаж байж манай эрдэмтэн судлаачид олон улсын түвшинд хүрэхүйц орчин нөхцөлд ажиллаж, эргээд төр засаг тэднээс дэлхийн түвшний үр дүнг шаардах боломжтой болох юм.

Хоёрдугаарт, Анхдугаар их хурлын зөвлөмжид шинжлэх ухаан, технологийн салбарын төсвийн санхүүжилтийн ДНБ-д эзлэх хувийг 2025 онд 2.5 хувьд хүргэх зорилт дэвшүүлсэн хэдий ч цар тахал, дэлхийн эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалан энэхүү зорилтыг ханган хэрэгжүүлэхэд тодорхой ахиц дэвшил гарч чадаагүй байна.

Иймд улсын эдийн засгийн өсөлттэй уялдуулан шинжлэх ухааны салбарын төсвийн санхүүжилтийг нэмэгдүүлэх, санхүүжилтийн шинэ эх үүсвэр бий болгох, Шинжлэх ухаан, технологийн санг дэлхийн жишигт нийцүүлэн хөгжүүлэх, шинжлэх ухааны салбарт Үндэсний баялгийн сангаас хөрөнгө төвлөрүүлэх зэрэг цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзэж байна.

Гуравдугаарт, Шинжлэх ухаан, технологийн олон улсын хамтын ажиллагаа, хамтарсан судалгааг эрчимтэй өргөжүүлэн хөгжүүлж, олон улсад өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх шаардлагатай байна. Шинжлэх ухаан, технологи, инновацын үйл ажиллагаа зөвхөн эх орондоо байгаа эрдэмтэн, судлаачдаар хязгаарлагдах учиргүй. Хилийн чанадад амжилттай ажиллаж буй эрдэмтэн, судлаачдаа сургалт, судалгааны ажилд зайнаас татан оролцуулах, гадаадын эрдэмтэн судлаачидтай хамтран хэрэгжүүлэх төсөл, судалгааг дэмжих замаар хил хязгааргүй оюуны дэд бүтэц үүсгэх нь нэн чухал юм.

Монгол Улс олон улсад үнэлэгдсэн эрдэмтэн судлаачдын төвлөрлийг бий болгох, орчин үеийн эрдэм шинжилгээ, судалгааны орчин нөхцөлийг бүрдүүлэх, санхүүжилтийн тогтолцоог дэлхийн жишигт хүргэх замаар олон улсад өрсөлдөх чадвартай шинжлэх ухаан, технологийн салбарыг хөгжүүлж чадна.

Дөрөвдүгээрт, Шинжлэх ухааны салбарын үйл ажиллагааны нэгэн чухал хэсэг болсон мэдлэгийг түгээн дэлгэрүүлэх, нийгмийг соён гэгээрүүлэх ажилд онцгой анхаарал хандуулах ёстой.

Бүх нийтийн шинжлэх ухааны мэдлэг боловсролыг дээшлүүлэх, хүүхэд залуусыг шинжлэх ухаанд шимтэн суралцуулах, шинжлэх ухаанч хандлагыг төлөвшүүлэх, хэвлэл мэдээллийн салбарынхан аливаа асуудалд шинжлэх ухаанч байр сууринаас ханддаг байх нь нийгмийг соён гэгээрүүлэх үйл хэрэгт чухал үүрэг гүйцэтгэх болно.

Тавдугаарт, ШУА-ийн харьяа хүрээлэнгүүд нийт санхүүжилтийнхээ 30-аас доошгүй хувьтай тэнцэх менежментийн орлого тогтвортой олох зорилт дэвшүүлэн ажиллаж байна. Энэ зорилтыг хэрэгжүүлэхийн төлөө хүрээлэнгүүдийн удирдлага идэвх санаачилгатай, манлайлан ажиллаж, байгууллагынхаа хөрөнгө, санхүүг нэмэгдүүлэх хэрэгтэй байна.

Эцэст нь, шинжлэх ухаан бол хүний өдөр тутмын амьдралын салшгүй хэсэг, түүний үр дүн нь бидний эрүүл, аюулгүй, таатай амьдралын баталгаа, улс орны тогтвортой хөгжлийн хөдөлгүүр билээ. Хамгийн өргөн утгаараа боловсрол, шинжлэх ухаан хоёр нь улс орны үндэсний аюулгүй



байдлын суурь болдог учраас ЕБС-ийн сурах бичгээс эхлээд үндэсний хэмжээний болоод стратегийн ач холбогдолтой томоохон хөтөлбөрүүдийг эрдэмтдээрээ экспертиз хийлгэсний дараа л эхлүүлдэг эрхзүйн орчин бүрдүүлэх талаар тодорхой ажлуудыг УИХ, Засгийн газарт хүргүүлж санаачилгатай ажиллаасай гэж хүсэж байна.